




The Asia Foundation



Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдог  
туслалцаа үзүүлэх үндэсний механизмын  
зураглал

Судалгааны тайлан

# **Хүн худалдаалах гэмт хэргийн хохилогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал**

**Судалгааны тайлан**

Улаанбаатар хот

2021 он

Тайланд дурдагдсан үр дүн, дүгнэлтүүд нь санхүүжүүлэгчийн байр суурийг илэрхийлээгүй, судалгааны явцад цуглуулсан мэдээлэлд тулгуурлан гаргасан судлаачдын дүгнэлт юм.

Судалгааг Азийн сангийн захиалгаар Хүйсийн тэгш эрх төв ТББ-ын судалгааны баг хийж гүйцэтгэв.

### **Судалгааны баг**

Г.Ганбаясгах	Ахлагч, Хүйсийн тэгш эрх төвийн тэргүүн
Л.Болор	Судлаач, Компас төвийн гүйцэтгэх захирал
С.Дондов	Судлаач, Иргэдэд туслах хүний эрхийн төвийн тэргүүн
Т.Цогзолмаа	Судлаач, Хүйсийн тэгш эрх төвийн Хохирогч хамгааллын хөтөлбөрийн менежер
Э.Хишигбаяр	Судлаач, Хүйсийн тэгш эрх төвийн Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн менежер

### **Техникийн зөвлөх**

М.Наран	Азийн сангийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх төслийн дэд менежер
Х.Онон	Азийн сангийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх төслийн ажилтан

### **Дизайнер**

Х. Мөнх-Ууган

## АГУУЛГА

Өмнөх үг .....	6
Товчилсон үг .....	7
Үр дүнгийн зураглалын жагсаалт .....	8
Зургийн жагсаалт .....	8
Хүснэгтийн жагсаалт .....	8

### **БҮЛЭГ 1: ЕРӨНХИЙ ТОЙМ .....**

1.1. Судалгааны зорилго, ач холбогдол .....	10
1.2. Судалгааны баг .....	11
1.3. Бүлгийн танилцуулга .....	11
1.4. Үр дүнгийн зураглал .....	12

### **БҮЛЭГ 2: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....**

2.1. Судалгааны үндэслэл .....	14
2.2. Судалгааны арга зүй .....	14
2.3. Судалгааны тайлан .....	15
2.4. Судалгааны хязгаарлагдмал байдал .....	16

### **БҮЛЭГ 3: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ .....**

3.1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин .....	17
3.1.1. Эрүүгийн хууль .....	17
3.1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль .....	18
3.1.3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль .....	19
3.1.4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль .....	19
3.2. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (Палермогийн протокол) .....	22
3.3. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сургалчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол .....	23
3.4 Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт .....	24
3.5. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, үйлдэл, арга хэлбэр .....	25
3.6. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээ .....	26

## **БҮЛЭГ 4: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ ..... 30**

4.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа, үйлчилгээнд хамрагдсан байдал .....	30
4.1.1. Хохирогч өөрөө хандах .....	30
4.1.2. Цагдаагийн байгууллага хохирогчийг илрүүлэх .....	31
4.1.3. Хохирогчийн ар гэрийнхэн хандах.....	32
4.1.4. Хохирогчийн найз нөхөд, танил тал нь хандах, хандуулах .....	32
4.1.5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн, төрийн бус байгууллагууд хандуулах .....	32
4.1.6. Хууль хяналтын байгууллагын ажилтнууд хандуулах .....	33
4.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй туслалцаа, үйлчилгээ.....	33
4.3. Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй туслалцаа, үйлчилгээний төрөл, үе шат.....	38
4.3.1. Анхан шатны туслалцаа .....	38
4.3.1.1. Хохирогчийг таньж мэдэх, илрүүлэх, тогтоох .....	39
4.3.1.2. Эх оронд нь эгүүлэн авчрах үйлчилгээ.....	41
4.3.1.3. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах.....	45
4.3.1.4. Хамгаалах байрны үйлчилгээ.....	49
4.3.1.5. Хууль зүйн туслалцаа .....	53
4.3.1.6. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ, үйлчилгээ .....	56
4.3.1.7. Эрүүл мэндийн үйлчилгээ .....	59
4.3.2. Эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ, туслалцаа .....	62
4.3.2.1. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт.....	63
4.3.2.2. Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ .....	66

## **БҮЛЭГ 5: ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭЖ БУЙ БУСАД УЛС ОРНЫ ТУРШЛАГА..... 68**

5.1. “4P”-ийн загвар .....	68
5.1.1. Урьдчилан сэргийлэх/Prevention.....	69
5.1.2. Хохирогч хамгаалал/Protection .....	69
5.1.3. Ял шийтгэл оногдуулах/Prosecution .....	70
5.1.4. Хамтын ажиллагаа/Partnership.....	70

5.2. Бусад улс орны туршлага .....	72
5.2.1. Филиппин Улс .....	72
5.2.2. Америкийн Нэгдсэн Улс .....	74
5.2.3. Бүгд Найрамдах Солонгос Улс .....	77
5.2.4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс .....	79
<b>ДҮГНЭЛТ .....</b>	<b>81</b>
<b>САНАЛ, ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>85</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....</b>	<b>86</b>

## Өмнөх үг

“Орчин үеийн боолчлол” хэмээн нэрлэгддэг хүний наймаа нь Монгол төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг татсан асуудлын нэг юм. Жил бүр сая сая хүмүүс хилийн чанадад төдийгүй эх орон дотроо худалдагдсаар байна. Бидэнд хүний наймаа гэдэг харь хол, манай улсад хэзээ ч үйлдэгдэхгүй гэж бодогддог байсан үе саяхан мэт боловч Монгол Улс Эрүүгийн хуульдаа хүн худалдаалах гэмт хэргийг тусгаснаас хойш өдгөө 20 орчим жил өнгөрч, тус гэмт хэрэгтэй тэмцэх багагүй туршлагыг хуримтлуулжээ.

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” гаргах судалгааны тайланг толилуулж байгаадаа бид баяртай байна. Монгол Улсад энэ гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрэлдэж, салбаруудын уялдаа холбоог хангасан хууль, журмууд батлагдан гарсан. Энэхүү судалгаагаар тэдгээрийн хэрэгжилт, төрөөс хуульчлагдсан үйлчилгээг хохирогч үнэ төлбөргүй авч чадаж байгаа эсэх болон эрсдэлд өртсөн тохиолдолд шуурхай тусламж, үйлчилгээ авах боломж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийлээ. Ингэхдээ хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагууд, тэднээр үйлчлүүлсэн хохирогчдоос цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, улмаар бусад орнуудын Монгол Улсад хэрэгжүүлж болохуйц сайн туршлагад тулгуурлан санал, зөвлөмж боловсрууллаа.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчдод үзүүлэх туслалцаа үйлчилгээг сайжруулах нь төрийн бодлогын хэсэг юм. Тиймээс ч бид тодорхой нэг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх зорилго агуулаагүй агаад хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизм, түүний хэрэгжилтийн бодит байдалд үндэслэн дүн шинжилгээ хийсэн болно. Эрсдэл өндөртэй гэрч, хохирогчдыг аюулгүй байлгах тусгайлсан байр, хувийн мэдээллийг нууцлах, насанд хүрээгүй хохирогчдод онцгойлон анхаарах, үйлчилгээний стандартыг мөрдүүлж хяналт тавих, мэргэжилтнүүдийг тогтмол сурган чадавхжуулах, холбогдох дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгах зэрэгт яагаад анхаарал хандуулах шаардлагатайг судалгааны тайлангаас дэлгэрүүлэн уншиж, бидэнтэй санал бодлоо хуваалцахыг хүсэж байна.

Судалгааны баг.

## Товчилсон үг

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ГХЯ	Гадаад хэргийн яам
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ДТГ	Дипломат төлөөлөгчийн газар
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЖҮХ	Жендэрийн үндэсний хороо
ЖГБТЭЯ	Жендэр, гэр бүл, тэгш эрхийн яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НАХЯ	Нийгмийг аюулаас хамгаалах яам
ОХУ	Оросын Холбооны Улс
ОУШХБ	Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УДШ	Улсын дээд шүүх
FDG	Дүфрен готьерын сан
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХХТБХЗ	Хүн худалдаалахтай тэмцэх байгууллага хоорондын зөвлөл
ХМТ	Холбооны мөрдөх товчоо
ХХТгХ	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМХҮЯ	Эрүүл мэнд хүний үйлчилгээний яам



## **Үр дүнгийн зураглалын жагсаалт**

- Зураглал 1. Судалгааны багаас ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээний бүтэц, механизмд санал болгож буй хувилбар
- Зураглал 2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар чиг үүрэг хүлээсэн салбар байгууллагууд
- Зураглал 3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй механизм

## **Зургийн жагсаалт**

- Зураг 1. Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан. 2020
- Зураг 2. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүй, бодлогын орчны цагалбар
- Зураг 3. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, үйлдэл, арга хэлбэр
- Зураг 4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээ
- Зураг 5. Нэн шаардлагатай туслалцаа, үйлчилгээ
- Зураг 6. Хохирогч өөрөө хандах
- Зураг 7. Хохирогчийн ар гэрийнхэн хандах
- Зураг 8. Хууль хяналтын байгууллагад хандсан хохирогчид шаардлагатай туслалцаа, үйлчилгээ
- Зураг 9. Хохирогчид үзүүлэх үндсэн үйлчилгээ
- Зураг 10. Төрийн бус байгууллагаас хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ
- Зураг 11. Кейс менежмент хийх үйл явц
- Зураг 12. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, тогтоох
- Зураг 13. 2020 онд ХХГХ-ийн хохирогчдыг эх оронд нь эгүүлэн авч ирэхэд үзүүлсэн санхүүгийн туслалцаа (байгууллагаар)
- Зураг 14. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ
- Зураг 15. Эрсдэлийн түвшинг тогтоох
- Зураг 16. Хууль зүйн туслалцааны хэлбэр
- Зураг 17. Хохирогч төрийн бус байгууллагаар дамжин хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэх үйл явц

## **Хүснэгтийн жагсаалт**

- Хүснэгт 1. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл
- Хүснэгт 2. Хохирогчид тулгамдаж буй асуудал, шаардлагатай үйлчилгээ
- Хүснэгт 3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр

- төрийн захиргааны төв байгууллагуудаас баталсан журмууд
- Хүснэгт 4. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх журмын товч танилцуулга
- Хүснэгт 5. Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг
- Хүснэгт 6. Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн ур чадвар олгох, сургалтад хамруулах журмын товч танилцуулга

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЕРӨНХИЙ ТОЙМ

### 1.1. Судалгааны зорилго, ач холбогдол

Судалгааны зорилго нь Монгол Улсын хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-тэй тэмцэх, хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлж буй тогтолцоо, үйлчилгээний механизмын талаарх өнөөгийн байдлыг судлахын зэрэгцээ бусад орны сайн туршлагаас судлан Монголд хэрэгжүүлж болохуйц санал, зөвлөмжийг дэвшүүлэхэд оршино.

Дээрх зорилгод хүрэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлэв. Үүнд:

1. ХХГХ-тэй тэмцэх, хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлэх тогтолцоо, үндэсний механизмын өнөөгийн нөхцөл байдлыг судлах;
2. ХХГХ-ийн хохирогчид үзүүлж буй туслалцаа, үйлчилгээний өнөөгийн зураглалыг гаргах;
3. Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй туслалцаа, үйлчилгээний талаар хохирогчдоос санал, дүгнэлт, хүсэлт авах;
4. ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах хууль тогтоомж болон Үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн хэрэгжилт, үүрэг хүлээсэн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр бусад орны туршлагыг судлах, Монгол Улсад нэвтрүүлэх санал зөвлөмжийг томъёолох зэрэг юм.

### Судалгааны ач холбогдол

- ХХГТ-тэй тэмцэж буй тогтолцооны өнөөгийн байдлыг төрийн болон ТББ, хохирогчдын оролцоотой тодорхойлсноор цаашид хохирогчдод үзүүлэх туслалцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд мэдээллийн эх үүсвэр болно.
- ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хохирогч хамгаалал, хамтын ажиллагааны чиглэлээр гаднын улсуудын туршлагыг судалж, эх орондоо нутагшуулах боломжтой сайн туршлагыг тодорхойлох нь бодлогын орчныг сайжруулахад дөхөм болно.
- Судалгааны тайланг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн болон ТББ-уудаар хэлэлцүүлж, саналыг тайланд тусгаснаар талуудын ойлголтыг нэгтгэн, цаашид бодлогын орчныг сайжруулахад нэмэр болно.

## 1.2. Судалгааны баг

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” гаргах зөвлөх судалгааны баг нь хохирогчдын эрхийг хамгаалах, бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх чиглэлээр 15-аас илүү жил тасралтгүй ажилласан туршлагатай мэргэшсэн судлаачдаас бүрдсэн.

### Багийн бүрэлдэхүүн:

Г.Ганбаясгах	Ахлагч, Хүйсийн тэгш эрх төвийн тэргүүн
Л.Болор	Судлаач, Компас төвийн гүйцэтгэх захирал
С.Дондов	Судлаач, Иргэдэд туслах хүний эрхийн төвийн тэргүүн
Т.Цогзолмаа	Судлаач, Хүйсийн тэгш эрх төвийн Хохирогч хамгааллын хөтөлбөрийн менежер
Э.Хишигбаяр	Судлаач, Хүйсийн тэгш эрх төвийн Урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн менежер

## 1.3. Бүлгийн танилцуулга

<b>Бүлэг 1.</b> Ерөнхий тойм	Судалгааны зорилго, зорилт, ач холбогдлын талаар дурдав.
<b>Бүлэг 2.</b> Судалгааны арга зүй	Судалгааны үндэслэл, арга зүй, аргачлалыг багтаав.
<b>Бүлэг 3.</b> Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт	Олон улсын болон үндэсний хууль тогтоомжид тусгагдсан ХХГХ-ийн талаарх үндсэн ойлголт, төрөл, нэр томъёоны тайлбарыг тусгалаа.
<b>Бүлэг 4.</b> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээний өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ	ХХГХ-ийн хохирогчийн үйлчилгээнд хамрагдсан байдал, шаардлагатай туслалцаа үйлчилгээний төрөл, мөн түүнчлэн төрийн болон ТББ-ын ХХГХ-ийн хохирогчид үзүүлж буй анхан шатны болон эргэн нийгэмшүүлэх үе шат дах туслалцаа, үйлчилгээ болон хуулиар үүрэг хүлээсэн байгууллагын даган мөрдөж буй хууль, журам, стандарт, тэдгээрийн уялдаа холбоо, хэрэгжилтийн одоогийн нөхцөл байдал, мөн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээл зэрэг үйлчилгээг боловсронгуй болгоход анхаарах асуудлуудыг нэгтгэн авч үзэж, дүн шинжилгээ хийсэн.
<b>Бүлэг 5.</b> Хүн худалдаалахтай тэмцэж буй бусад улс орны туршлага	Олон улсад хэрэгжиж буй “4Р” загвар болоод АНУ, БНСУ, БНХАУ, Филиппин улсуудын ХХГХ-тэй тэмцэж буй тогтолцоо, тэр дундаа хохирогчийг илрүүлэх, хохирол барагдуулах, нөхөн төлбөр олгох механизм, ТББ-ын оролцоо, тэдгээрт үзүүлэх дэмжлэг зэргийг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэв.

## 1.4. Үр дүнгийн зураглал


**Зураглал 1.** Судалгааны багаас ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх туслалцаа, үйлчилгээний бүтэц, механизмд санал болгож буй хувилбар





# ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ: МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль




Зураглал 2. ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИАР ЧИГ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН САЛБАР БАЙГУУЛЛАГУУД



**Зураглал 3. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БҮЙ МЕХАНИЗМ**

# ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗУРАГЛАЛ



**ПРОКУРОР**

**ШҮҮХ**

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

- Анхан шатны тусалцаа**
- Нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө
    - ХХГХ-ийн хохирогчийг тогтоох
    - Нөхцөл байдлын үнэлгээ хийх
    - Хохирогчийн хүсэлтээр хуулийн байгууллагад хандуулах
    - Эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр боловсруулах
    - Ар гэртэй нь холбоо тогтоох

- Хууль зүйн зөвлөгөө
  - Анхан шатны хууль зүйн зөвлөгөө
  - Хуулийн байгууллагад хандахад тусалцаа үзүүлэх
  - Хэргийн явцын талаар тогтмол мэдээллээр хангах
  - Боломжтой нотлох бүрдүүлэхэд тусалцаа үзүүлэх

- Эрүүл мэндийн тусалцаа
  - Сайн дурын үзлэг, шинжилгээнд хамруулах
  - Яаралтай тусламж үзүүлэх
  - Зайлшгүй нөхцөлд эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх

- Хамгаалах байр
  - Шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгчийн хүсэлтээр байрлуулах
  - Богино хугацааны (1-6 сар)
  - Урт хугацааны (1-12 сар)

- Эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ**
- Эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх
  - Сэтгэлзүйн зөвлөгөө, засал
  - Эрүүл мэндийн эмчилгээ
  - Өмгөөллийн тусалцаа
  - Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт
  - Амьдрах ухааны сургалт
  - Үнэлгээ хийх

- Нөхөн сэргээх хөтөлбөр**
- Үнэлгээний үр дүнд тулгуурлан хэрэгжүүлэх
    - Гэр бүлд эргэн нэгтгэх
    - Ажлын байранд зуучлах
    - Бичил бизнес эхлэхэд туслах
    - Гэр авч өгөх

**Анхан шатны шүүхээр хэрэг шийдвэрлэх**

**Давах шатны шүүхээр хэрэг шийдвэрлэх**

**Хяналтын шатны шүүхээр хэрэг шийдвэрлэх (дээд шүүх)**

- Гэмт хэргийг шийдвэрлэх
  - Гэм буруугийг тогтоож цагаатгах
  - Гэм буруутайг тогтоож ял шийтгэл оногдуулах
  - Хэргэсэхгүй болгох
- Хохирогчид хохирлыг тооцож олгуулах шийдвэр
  - Сэтгэл санааны хохирол
  - Эрүүл мэндийн хохирол
  - Эд материалын хохирол
- Хэргийг буцаах
- Шийдвэрийг хэвээр үлдээх
- Шийдвэрийг өөрчлөх
- Хэргийг хэргэсэхгүй болгох
- Хэргийг буцаах
- Шийдвэрийг хэвээр үлдээх
- Шийдвэрийг өөрчлөх
- Хэргийг хэргэсэхгүй болгох
- Гомдлыг хэлэлцэхгүй

## ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 2.1. Судалгааны үндэслэл

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь хэдийгээр манайд шинэ тутам сонсогддог ч хэдийнээ 20 орчим жилийн туршлага хуримтлуулжээ. Монгол Улсын Засгийн газраас ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тасралтгүйгээр, жилийн жилд ахисан түвшинд ажиллаж буй бөгөөд АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай” тайланд 2006 оноос эхлэн тайлангаа тогтмол илгээж сүүлийн 14 удаад хоёрдугаар шатлалд<sup>1</sup> эрэмбэлэгдсэн. Энэхүү тайланд “Хүн худалдаалахыг арилгах хамгийн доод стандарт”-ыг дагаж мөрдөх хүчин чармайлтыг улс орон бүрээр эрэмбэлдэг ба 1, 2, 3 шатлал (Tier) болон 2 дугаар шатлалын ажиглалтын буюу анхаарал татаж буй орнууд гэсэн ангиллаар улс орнуудыг жагсаадаг. 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын илтгэлд 190 орон эрэмбэлэгдсэний 18% нь 1 дүгээр шатлалд, 47% нь 2 дугаар шатлалд, 24% нь 2 дугаар шатлалын анхаарал татах орнуудад, 10% нь 3 дугаар шатлалд, 3 улс онцгой нөхцөлтэй улсад эрэмбэлэгджээ<sup>2</sup>.

Зураг 1. “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай” тайлан (2020)



Монгол Улсад хүний наймаатай тэмцэх чиглэлээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2013), Эрүүгийн хууль (2015), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) болон хуулийг даган гарсан 20 гаруй журам, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр (2017-2021) зэрэгт дурдагдсан хохирогч хамгааллын үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа болон энэ чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг, оролцооны талаар мэдээлэл хомс, үр дүнг үнэлсэн болон үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар тусгайлсан тайлан гараагүй байна.

<sup>1</sup> АНУ-ын Төрийн Департамент, “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай” тайлан /2020/, <https://www.state.gov/reports/2020-trafficking-in-persons-report/Mongolia/>

<sup>2</sup> <https://www.state.gov/reports/2020-trafficking-in-persons-report/>



Хүйсийн тэгш эрх төв ТББ-аас 2010 онд “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал” судалгааны тайланг боловсруулан гаргаснаас хойш өнөөг хүртэл ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, тогтолцооны зураглалын өөр судалгаа хийгдээгүй байна.

ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлснээр 2018-2020 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах 38 хэрэг бүртгэгдэж, 131 хохирогч тогтоогдсон байна. Мөн хугацаанд Хүйсийн тэгш эрхийн төв нь 119 хохирогчид туслалцаа үзүүлж, шүүхээр нийт 12 эрүүгийн хэргийг шийдвэрлүүлжээ.

Дэлхий нийтийг хамарсан “КОВИД-19” цар тахал охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүл, эдийн засагт сөргөөр нөлөөлж, жендерг суурилсан хүчирхийллийг улам нэмэгдүүлж буйг олон улсын болон дотоодын судалгааны тоон мэдээ харуулж байна. Тухайлбал, 2020 онд төр, төрийн бус, олон улсын байгууллагууд хамтран ХХГХ-ийн хохирогч байх магадлалтай Монгол Улсын 20 иргэнийг Малайз улсаас эх оронд нь буцаан авчирчээ.<sup>3</sup>

Монгол Улсад 2020 оны дүнгээр 25,388<sup>4</sup> ТББ үйл ажиллагаа явуулж буй ч хүний эрх, жендергт суурилсан хүчирхийлэл, хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг байгууллага цөөн. Ялангуяа ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр 10 орчим байгууллага ажиллаж байгаагаас тав нь хохирогчид туслалцаа, үйлчилгээ үзүүлж байна.

Иймд бид энэхүү “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын зураглал” судалгаагаар хохирогч хамгаалал, тэдэнд үзүүлэх туслалцаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж дэвшүүлж байна.

## 2.2. Судалгааны арга зүй

Судалгааг чанарын (ганцаарчилсан ярилцлага) болон баримт бичгийн судалгаа (баримт, тоо мэдээнд дүн шинжилгээ хийх)-ны загвар, арга зүйг ашиглан гүйцэтгэв.

**Ганцаарчилсан ярилцлага:** Хууль сахиулах, шүүх эрх мэдэл, төрийн болон ТББ-уудын ажилтан, албан хаагч, удирдлагуудтай ярилцав. “КОВИД-19” цар тахлын үеийн өндөржүүлсэн бэлэн байдалд шилжиж, хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор биечлэн уулзах боломжгүй тохиолдлуудад цахим суваг (утас, Zoom, Google Meets, и-мэйл зэрэг) ашиглан ярилцлага хийлээ.

- **Төрийн байгууллага:** Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийн Ажлийн алба, Хүний эрхийн Үндэсний Комисс, Шүүхийн ерөнхий зөвлөл, Прокурорын байгууллага, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн

<sup>3</sup> Хүйсийн тэгш эрх төвийн 2020 оны үйлчилгээний тоон мэдээллээс.

<sup>4</sup> Дам эшлэв. ХЗДХЯ, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2021 он

албаны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасаг, ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Цагдаагийн Газрын харьяа Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтан, ахлах мэргэжилтэн, өмгөөлөгч, мөрдөгч, эрүүгийн мөрдөгч зэрэг нийт 25 хүн оролцсон. Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд судалгаанд ажилд туслалцаа үзүүлэх талаарх хүсэлт илгээсэн боловч хариу ирүүлээгүй тул судалгаанд хамрагдаагүй болно.

- **Төрийн бус байгууллага:** Хүйсийн тэгш эрх төв, Иргэдэд туслах хүний эрхийн төв, Талита Ази, Анбаунд Монгол, Экпат Монгол ТББ зэрэг ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тогтвортой ажиллаж байгаа таван байгууллага хамрагдсан. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Үндэсний сүлжээ рүү ярилцлагын хүсэлт илгээсэн боловч хариу өгөөгүй тул мэдээлэл авч чадсангүй.
- **Хохирогч:** Хилийн чанадад болон эх орон дотроо ХХГХ-ийн бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон нийт 20 охид, эмэгтэйчүүдээс ярилцлага авсан.

**Баримт бичгийн судалгаа:** Эрүүгийн хууль (2015), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017), Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2013), Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021), Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан (2019) болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй төрийн, хууль сахиулах болон мэргэжлийн хяналтын, ТББ-ын үйл ажиллагаанд баримталж байгаа дүрэм, журам, стандарт, тоо мэдээ, судалгаа, үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийсэн.

**Бусад орны туршлага:** Хүн худалдаалахтай амжилттай тэмцэж, сайн туршлага хуримтлуулсан улс орнуудаас АНУ, БНСУ, БНХАУ болон Филиппин улсыг сонгон судалж, хохирогчийг илрүүлэх, мэдээлэх, хохирогч хамгаалал, гэмт хэргийг шийдвэрлэх төрийн үйлчилгээний тогтолцоо, хохирол барагдуулах, нөхөн төлбөр олгох механизм, ТББ-ын оролцоо, дэмжлэг зэргийг судалсан.

#### **Мэдээлэл боловсруулалт:**

Судалгааны мэдээллийг Microsoft Word, Excel, PowerPoint програмуудын тусламжтай боловсруулан, судалгааны тайланг багийн гишүүд хамтран бичлээ.

**Тайлангийн хэлэлцүүлэг:** Судалгааны тайланд орсон мэдээллийг баталгаажуулах, зөвлөмж, дүгнэлтэд санал авах зорилгоор хоёр удаагийн хэлэлцүүлгийг төрийн болон ТББ-ын ажилтнуудын дунд зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан болон тусгайлан өгсөн саналуудыг тайланд тусгалаа.

### **2.3. Судалгааны тайлан**

Тайланг монгол хэлээр бичиж, гол үр дүнг зураглал хэлбэрээр харууллаа.

#### 2.4. Судалгааны хязгаарлагдмал байдал

Дэлхий нийтийг хамарсан КОВИД-19 цар тахлын улмаас олон удаагийн өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы дэглэмд шилжсэний улмаас төлөвлөгөөний дагуу хүн бүртэй ганцаарчилсан уулзалт, бүлгийн ярилцлага хийх боломж хязгаарлагдмал байлаа. Мөн судалгаанд авагдсан мэдээлэл нь зөвхөн нэг удаагийн ярилцлагаар авагдсан мэдээллүүд учир тухайн байгууллагыг үйл ажиллагааг бүхлээр нь хамарсан гэж үзэх боломжгүй юм. Судалгаанд цар тахлын онцлог байдлаас шалтгаалан ХХГХ-ийн хохирогч болсон гадаадын иргэдийг оролцуулах боломжгүй байсан тул Монгол Улсын иргэд тэр дундаа эх орондоо дотроо болон хилийн чанадад бэлгийн мөлжлөгийн зорилгоор ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүд оролцсон. Дүн шинжилгээнд сүүлийн 3 жилийн буюу 2019-2021 оны тоо мэдээллийг ашигласан болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

### 3.1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин

Монгол Улс анх 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлээр хүн худалдах, худалдан авах гэсэн бие даасан эрүүгийн гэмт хэргийг хуульчилсан. 2008 онд НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт протокол болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (Палермогийн протокол)-д нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжуудаа олон улсын стандартад нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийсээр ирсэн. Эрүүгийн хуульд 2008, 2015 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан, Палермогийн протоколын үндсэн зорилгын тодорхойлолтод нийцүүлжээ. 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хууль баталж, энэ гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийг хамгаалахад салбар тус бүрийн үүрэг оролцоог тодорхойлж өгсөн. Хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх тал дээр бодлогын томоохон өөрчлөлтүүд гарсан нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хохирогчийн эрхийг хамгаалах бүлэг<sup>5</sup> орсон зэрэг болно.

Түүнчлэн, ХХГХ-тэй тэмцэх бодлого, хэрэгжилтийн хувьд олон ахиц гарч, Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөр (2005-2011, 2017-2021), Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөр (2016-2024)-ийг батлан хэрэгжүүлж, үйл ажиллагаа, бодлого, салбар дундын хамтын ажиллагааг удирдан зохицуулах Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийг байгуулан ажиллаж, тодорхой үр дүнгүүд гарч эхэлж байна.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиудад тусгагдсан онцлох заалтуудыг дор танилцуулж байна.

#### 3.1.1. Эрүүгийн хууль<sup>6</sup>

Хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино. Хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оны 07 дүгээр сарын 01-ний өдрөөс даган мөрдөж байна.

<sup>5</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 8-р бүлэг, Хохирогч, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч, <https://www.legalinfo.mn/law/details/12694?lawid=12694> .

<sup>6</sup> <https://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634>.

### 13.1 дугаар зүйл. Хүн худалдаалах

Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор:

хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тэвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийг:

- хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;
- хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;
- Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- байнга тогтвортой;
- зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

**Тайлбар:** Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

### 12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг

Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар, хүндрүүлэх нөхцөлтэйгөөр үйлдсэн бол 5-20 жил хүртэл эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ.

Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор:

- Арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж;
- урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн;
- хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж;
- хохирогчийг жирэмсэн болгож; хоёр, түүнээс олон хүний эсрэг;
- бага насны хүүхдийг албадан оруулж үйлдсэн бол хүндрүүлэх нөхцөлд тооцно.

**Тайлбар:** Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

### **3.1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>7</sup>**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм

<sup>7</sup> <https://www.legalinfo.mn/law/details/12694?lawid=12694>.

буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино. Хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хохирогч” гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно гэжээ. Мөн хуулийн 8.2 дугаар зүйлд хохирогчийн эрх, үүргийг хуульчилсан ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчоор тогтоогдсон хүн 15 эрх эдэлж, дөрвөн үүрэг хүлээх зохицуулалттай. Тус хуулийг 2017 онд баталж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс даган мөрдөж эхэлсэн.

### **3.1.3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль<sup>8</sup>**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2012 онд баталсан бөгөөд зорилт нь хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шалтгаан нөхцөлийг тогтоон арилгах, хохирогчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хуулиар хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зохион байгуулалт, арга хэлбэрийг зохицуулсан.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар “хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ гэж онцлон тодорхойлж өгсөн нь хохирогч хамгааллын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой заалт болсон юм. Хуулийг даган гарах учиртай долоон журмаас тав нь батлагдсан байна.

Уг хуулиар хохирогчид эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэхээр заасан бөгөөд гадаад улсад Монгол Улсыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрууд хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах үүрэг хүлээсэн.

### **3.1.4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль<sup>9</sup>**

Энэ хуулийн зорилт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтооход оршино. Хуулиар аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг гэрч, хохирогчид үзүүлэхээр зохицуулсан. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээнд: урьдчилан сануулах, тодорхой үйлдлийг хязгаарлах, биечилсэн хамгаалалт, мэдээллийн нууцлалыг хангах, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах, аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг

<sup>8</sup> <https://www.legalinfo.mn/law/details/554?lawid=554>.

<sup>9</sup> <https://www.legalinfo.mn/law/details/554?lawid=554>.

солих, гадаад төрхийг өөрчлөх зэрэг багтдаг. Хуулийг дагаж есөн журмыг батлан хэрэгжүүлж байна. Энэ хуулийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

**Зураг 2.** Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүй, бодлогын орчны цагалбар







2002 онд Эрүүгийн хуульд анх удаа шинэ төрлийн гэмт хэрэг болгон тусгасан цагаас эхлэн хүн худалдаалахтай тэмцэх эрх зүй, бодлогын орчинд олон ололт амжилт гарсан ч зарим нэг ухралт гарсан нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий Тахарын албыг 2014 онд шинээр байгуулаад хоёрхон жилийн дараа татан буулгасан явдал юм.



### 3.2. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (Палермогийн протокол)

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 55/25 тогтоолоор баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”<sup>10</sup> нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын гол баримт бичиг юм. Конвенцод нэмэлт гурван Протокол байдгийн нэг нь Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол юм. Улс орнууд уг Протоколд нэгдэхээс өмнө Конвенцод нэгдэж орох ёстой байдаг.<sup>11</sup>

“Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол” буюу Палермогийн протоколыг НҮБ-ын гишүүн орнууд хуралдаж, энэхүү олон улсын гэрээнд гарын үсэг зурсан Италийн Палермо хотын нэрээр нэрлэжээ. Энэхүү Протокол нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар олон улсын түвшинд харилцан тохиролцсон тодорхойлолт бүхий анхны хууль ёсны хэрэгсэл болсон юм. 2020 оны тавдугаар сарын байдлаар 178 улс энэхүү Протоколд нэгдсэн. Протоколыг хэрэгжүүлэх ажлыг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC) хариуцдаг. НҮБ-аас Монгол Улсыг 2008 оны 6-р сарын 27-ны өдөр Палермогийн протоколд нэгдэн орсноор бүртгэжээ.<sup>12</sup> Энэхүү Протоколд нэгдэн орсноор Монгол Улс түүний агуулгад үндэсний хууль тогтоомжоо нийцүүлэн сайжруулах, хэрэгжилтийг хангах ажлыг алхам алхмаар хийсээр иржээ.

Протоколоор дараах ойлголт, тодорхойлолтуудыг нэг мөр болгожээ. Үүнд:

/а/ “хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.

**Мөлжих** гэдэгт наад зах нь бусдыг биеийг нь үнэлүүлэх буюу бэлгийн харилцаанд оруулан мөлжих бусад хэлбэрүүд, албадан ажиллуулах буюу үйлчлүүлэх, боолчлол буюу боолчлолтой төсөөтэй заншил, эрх чөлөөгүй

<sup>10</sup> 2003 оны 9-р сарын 29-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон.

<sup>11</sup> Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц ба түүний нэмэлт, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>.

<sup>12</sup> Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, [https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg\\_no=XVIII-12-a&chapter=18&clang=en](https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XVIII-12-a&chapter=18&clang=en).

байлгах буюу эрхтнийг нь авах зэргийг ойлгоно;

/b/ энэхүү зүйлийн /a/ дэд хэсэгт дурдсан аргуудын аль нэгийг ашигласан байх тохиолдолд хүн худалдаалах хэргийн хохирогч өөрийг нь /a/ дэд хэсэгт дурдсанаар мөлжих гэж байгааг өөрөө зөвшөөрснийг хэрэгсэхгүй;

/c/ энэхүү зүйлийн /a/ дэд хэсэгт дурдсан аргуудыг хэрэглээгүй байсан ч мөлжих зорилгоор хүүхдийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг “хүн худалдаалах” гэж үзнэ.

/d/ Хүүхэд гэдэгт 18 нас хүрээгүй хүн бүрийг хэлнэ.

### **3.3. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол<sup>13</sup>**

Энэхүү нэмэлт Протоколыг “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ын зорилтыг хангах, заалтуудыг хэрэгжүүлэх, хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах явдлаас хүүхдийг хамгаалах зорилгоор оролцогч улсуудын зүгээс илүү өргөн хүрээний арга хэмжээ авхуулах үүднээс 2000 онд батлан гаргажээ. Монгол Улс уг Протоколд 2002 онд<sup>14</sup> нэгдэн орсон.

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах явдлыг устгахад

- нөлөөлөгч хүчин зүйлс болох буурай хөгжил, ядуурал, эдийн засгийн шударга бус байдал, нийгэм эдийн засгийн тэгш бус байдал, зөрчилтэй гэр бүлүүд, боловсролын хүртээмжгүй байдал, хөдөөгөөс хот руу шилжилт хөдөлгөөн, жендэрийн ялгаварлан гадуурхалт, хариуцлагагүй насанд хүрэгчдийн бэлгийн зан үйл, халтай уламжлалт зан үйлүүд, зэвсэгт мөргөлдөөн болон хүүхдийг хууль бусаар тээвэрлэх зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх;

-хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх болон хүүхдийг садар самуунд сурталчлах эрэлт хэрэгцээг багасгахын тулд олон нийтийг мэдээлэлжүүлэх чиглэлээр хүчин чармайлт гаргах;

-бүх оролцогч талуудын дэлхий нийтийн түншлэлийг бэхжүүлэхэд онцгой анхаарч, үндэсний хэмжээнд хуулийн хэрэгжилтийг сайжруулах нь чухал гэж үзжээ.

Монгол Улсын Засгийн газраас нэмэлт протоколын хүрээнд 2007 онд НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороонд бие даасан анхны тайлан илтгэлийг илгээж, 2010 онд дүгнэлт, зөвлөмжийг хүлээж авсан. Нэмэлт протоколын тайланг ХЭК-

<sup>13</sup> НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000.5.25-ны өдрийн A/RES/54/263 тогтоолоор баталж, 2002 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 2002.10.11-нд гарын үсэг зурж, 2003.5.15-нд нэгдэн орсон.

<sup>14</sup> <https://www.legalinfo.mn/law/details/1274>.

ын тайлантай нэгтгэн тайлагнадаг болсон ч энэ асуудлаар хангалттай тайлан мэдээлэл ирээгүй гэж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо үзжээ<sup>15</sup>.

Протоколын 2 дугаар зүйлд дараах тодорхойлолтуудыг нэг мөр болгожээ. Үүнд:

(a) хүүхдийг худалдах гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг;

(b) хүүхдийн биеийг үнэлэх гэж шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг;

(c) хүүхдийг садар самуунд сурталчлах гэж хүүхдийг ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх буюу бэлгийн зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг хэлнэ гэж тодорхойлсон.

#### 3.4. Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт

Хүн худалдаалах гэмт хэргийг Монгол Улсын эрх зүйн орчны хүрээнд дараах байдлаар тодорхойлжээ. Эдгээр тодорхойлолтуудыг нэгдэн орж, соёрхон баталсан НҮБ-ын Палермогийн протоколын тодорхойлолтод нийцүүлэн зорилго, үйлдэл, арга замыг тусгасан.

*Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль*<sup>16</sup>: “Хүн худалдаалах” гэж хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг хэлнэ.

*Эрүүгийн хууль*<sup>17</sup>: “Хүн худалдаалах” гэж биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

<sup>15</sup> НҮБ-ын ХЭК-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5-р тайлан илтгэлтэй холбогдуулан НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооноос өгсөн зөвлөмж, <https://mlsp.gov.mn/content/detail/1084>

<sup>16</sup> Төрийн мэдээлэл, 2012 он, дугаар 07.

<sup>17</sup> Төрийн мэдээлэл, 2016 он, дугаар 07.

Мөн Улсын дээд шүүхээс 2008 онд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор тайлбарыг гаргасан байдаг<sup>18</sup>. Уг тайлбарт: “Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно.

### 3.5. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, үйлдэл, арга хэлбэр

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), Эрүүгийн хууль (2015)-д ХХГХ-ийн зорилго, төрөл, үйлдэх арга хэлбэр, үйлдлийг тодорхой зааж өгсөн байдаг.

**Зураг 3.** Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, үйлдэл, арга хэлбэр



**Тайлбар:** Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход дээрх арга хэлбэрээр үйлдсэн байхыг шаардахгүй.

Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь дээр дурдсан арга хэлбэрээр хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

2008 онд УДШ-ээс батлан гаргасан тайлбарт хүн худалдаалах гэмт хэргийн төрлүүдийг дараах байдлаар тайлбарлажээ.<sup>19</sup>

<sup>18</sup> <https://www.legalinfo.mn/law/details/657?lawid=657>

<sup>19</sup> Мөн тэнд.

<i>ХХГХ-ийн төрөл</i>	<b>Агуулга</b>
<i>Биеийг нь үнэлүүлэх</i>	Хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.
<i>Бэлгийн хүчирхийлэлд оруулах</i>	Биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан', бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно.  Өрийн дарамтад оруулах зэргээр биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.
<i>Албадан хөдөлмөр хийлгэх</i>	Хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.
<i>Боолчлох</i>	Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.
<i>Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах</i>	Хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.
<i>Эд эрхтнийг нь авч ашиглах</i>	Хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.


### **3.6. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үзүүлэх туслалцаа, үйлчилгээ**

ЕАБХАБ-ын ХХГХ-тэй тэмцэх асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Мадина Ярбуссинова “Хүн худалдаалахтай тэмцэх асуудлыг Засгийн газрын оролцоотой хийхгүй бол үр дүн гарахгүй бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндсэн асуудлын нэгийг “Хүн худалдаалахтай тэмцэх” болгох шаардлагатай” гэж Монгол Улсад өгсөн зөвлөмждөө цохон тэмдэглэжээ. Манай улс энэ чиглэлээр багагүй ажлуудыг хийж, ахиц гаргаж буйн илэрхийлэл нь Хүн худалдаалахтай тэмцэх бие даасан хууль батлагдаж, хуулийн хэрэгжилтийг хангах журмууд батлагдан гарч, үндэсний хөтөлбөрүүдтэй болсон явдал юм. Мөн ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандартыг<sup>20</sup> 2013 онд батлан гаргаж, хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, үе шатыг тодорхойлсон. Уг стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа

<sup>20</sup> Стандартчилал хэмжил зүйн газар, “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6418:2013”, 2013 он, Улаанбаатар хот.

явуулж буй ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх бүх ТББ мөрдөх үүрэгтэй юм. Хохирогчид нөхцөл байдлаасаа хамааран дараах таван төрлийн үйлчилгээнд хамрагдахаар тусгажээ.

**Зураг 4.** ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх туслалцаа, үйлчилгээ



Гэвч энэ стандартыг төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа баримтлахаар зохицуулаагүй нь учир дутагдалтай. Энэхүү стандартад хохирогчийг тогтоох жишиг маягтаас эхлэн улс даяар нэгдсэн журмаар үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар нэгдсэн журмыг зааж өгсөн ч дагаж мөрдөх хүрээг зөвхөн ТББ гэж хязгаарласнаар стандартыг өргөн хүрээнд ашиглах боломжийг хязгаарласан байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хэвийн амьдралдаа эргэн орж, нийгэмшихэд дараах асуудал нийтлэг тохиолдож байгаа бөгөөд ТББ-ууд доорх байдлаар туслалцаа, үйлчилгээ үзүүлж байна.


**Хүснэгт 2.** Хохирогчид тулгамдаж буй асуудал, шаардлагатай үйлчилгээ

Тулгамдаж буй асуудал	Шаардлагатай үйлчилгээ
<b>Санхүү:</b> Орлогын эх үүсвэргүйгээс болж бусдаас хараат байдал ордог. Иймээс биеэ даан амьдрахад хүндрэлтэй байдаг.	<b>Тусалцаанд хамрагдах:</b> Эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжтой. Мөн мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтаа амжилттай дүүргэсэн тохиолдолд ажлын байранд хэрэгцээт анхан шатны тоног төхөөрөмжийн тусламж, дэмжлэгт хамрагдах боломжтой.
<b>Айдас:</b> Гэмт хэрэгтнүүдээс айх айдсаас гадна бусад хүмүүс энэ талаар мэдсэн байх вий, олон нийтийн сүлжээнд мэдээлэл тарчих вий гэсэн айдас, туслалцаанд хамруулж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарчих болов уу гэсэн эргэлзээ, айдас бий.	<b>Өмгөөлөгчтэй байх:</b> Гэмт хэрэгтнүүдээс ирэх дарамтыг бууруулах, цагдаагийн байгууллагад мэдээлж аюулгүй байдлыг хангуулах, хохирогчийн эрхийг хамгаалахад хамтран зүтгэгч болдог.

<p><b>Гэр бүл, найз нөхдийн харьцаа, хандлага:</b> Хохирогчдод тулгарч буй бэрхшээлийн голлох хэсэг нь ар гэр, найз нөхдийн харьцаа, хандлагад гарч буй өөрчлөлт байдаг. Ар гэрийнхэн нь гэрээс гарч, орох, бусадтай холбоо тогтоох бүх үйлдэлд хяналт тавих, оролцох, хориглох бол найзууд зайгаа барих, эсвэл бусдадаа худал мэдээлэл дамжуулах зэргээр харьцаа, хандлага өөрчлөгддөг.</p>	<p><b>Ар гэрийнхэнтэй нь ойлголцуулах:</b> Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн оролцоотойгоор хохирогчийг (насанд хүрсэн бол өөрийнх нь хүсэлтээр) ар гэрийнхэнтэй нь ойлголцуулж өгөх, хэвийн амьдралдаа эргэн ороход нь туслалцаа үзүүлдэг.</p>
<p><b>Гэр бүлийн орчин:</b> Эмзэг байдал нь арилахгүй байх, хохирогчийг буруутгах хандлага гарах, эсвэл гэрт хамт амьдрах боломжгүй, хүчирхийлэл дарамттай байх, өнчин болон асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй байх зэрэг асуудлууд.</p>	<p><b>Сэтгэл зүйн болон хууль зүйн зөвлөгөө:</b> Зөвлөгөө өгөх, мэргэжлийн чиг баримжаатай болгох, ажилд зуучлах зэргээр эмзэг байдлыг бууруулах, нэн шаардлагатай тохиолдолд орон гэртэй болоход туслах, жижиг гарааны бизнес эрхлэхэд туслах зэргээр эмзэг байдлыг бууруулах оролдлого хийгддэг.</p>

Хохирогчид ТББ-уудад хандаж заавал шийдүүлж өгөх дараах санал, хүсэлтийг гаргасан.

**Зураг 5.** Нэн шаардлагатай туслалцаа, үйлчилгээ



Дээрх хүсэлтүүдээс харахад ХХГХ-ийн хохирогчдод аюулгүй байдлын хамгаалалт, эдийн засгийн бие даасан байдал, бусдаас хараат бусаар амьдрах нөхцөл боломж, удаан хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ, амьдрах орон байрны

асуудал зэрэг нь тулгамдсан хэвээр байна. Хохирогч хуулийн байгууллагад хамгийн их итгэл найдвар тавьж, асуудлаа шийдүүлэн хохирлоо барагдуулна гэж боддог ч гэмт хэрэгтэнд шударгаар ял шийтгэл оногдуулж буй нь эргэлзээтэй байдаг, мөн хохирогчид нөхөн олговор олгох, эдийн, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх шүүхийн шийдвэр гардаггүйгээс олон хохирогч хуулийн байгууллагад итгэх итгэлээ алдахад хүрч байгааг илэрхийлсэн нь цаашид бодлогын хувьд анхаарах асуудлын нэгт зүй ёсоор орж байна.



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИД ҮЗҮҮЛЭХ ТУСЛАЛЦАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 4.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа, үйлчилгээнд хамрагдсан байдал

Төрийн болон ТББ-д хандаж, үйлчилгээнд хамрагдсан 16-33 насны 20 хохирогчтой ганцаарчилсан ярилцлагыг хийсэн. Мөн 2020 онд Эрүүгийн хуулийн 13.1 дэх зүйлээр шийдвэрлэгдсэн анхан шатны шүүхийн тогтоолуудад дүн шинжилгээ хийсэн.

#### *Шигтгээ 1.*

*2020 оны 05 дугаар сард Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13 дугаар зүйл болох “хүн худалдаалах”-аар шийдвэрлэгдсэн хэрэгт таван шүүгдэгч, 11 хохирогч тогтоогдсоны таван нь насанд хүрээгүй хохирогч байсан.*

Эх сурвалж: [www.new.shuukh.mn](http://www.new.shuukh.mn)

Судалгаанд хамрагдсан хохирогчдын ес нь насанд хүрээгүй<sup>21</sup>, үлдсэн 11 нь насанд хүрсэн охид, эмэгтэйчүүд байв. Насанд хүрсэн хохирогчид бүгд өрх толгойлсон, нэгээс гурван хүүхэдтэй эмэгтэйчүүд байлаа. Тэд ХХГТ-т өртсөн гол шалтгаанаа гэр бүлийн хүчирхийлэл, дарамт, зөрчил, хойд эцэг, эхтэйгээ хамт амьдардаг, тэдэнтэй таагүй харилцаатай байсан, үе тэнгийнхэн, найз нөхдөдөө уруу татагдан, хууртагдсан гэжээ. Мөн хохирогчдын дийлэнх нь бага, бүрэн дунд боловсролтой, мэргэжилгүй, тогтмол орлогогүй, өр зээлтэй байжээ.

Хохирогчид эргээд хэвийн амьдралдаа ороход дараах асуудал нийтлэг тохиолдож байх бөгөөд дараах байдлаар ТББ-ууд шийдвэрлэж байна.

#### **4.1.1. Хохирогч өөрөө хандах**

Судалгаанд хамрагдсан нийт хохирогчдын 10 (50%) нь төрийн болон ТББ-д өөрөө хандсан бөгөөд шалтгаан нь аюулгүй байдлаа хангуулах, гэмт хэрэгтний дарамт шахалтаас зугтан, туслалцаа, үйлчилгээ хүссэн байна.

<sup>21</sup> Тайлбар: Насанд хүрээгүй хохирогчидтой ганцаарчилсан ярилцлага хийхдээ эцэг, эхээс нь зөвшөөрөл авч, гарын үсэг зуруулсан.

## Зураг 6. Хохирогч өөрөө хандах



Дотоодод үйлдэгдэж буй ХХГТ-т өртсөн хохирогчид аюулгүй байдлаа хангуулах, хамгаалах байранд байрлах, урт хугацааны хамгаалалт, гэмт хэрэгтний дарамт шахалтаас зугтах болон санхүүгийн бодит дэмжлэг хүсдэг. Гадаад ХХГТ-т өртсөн хохирогчдын хувьд эх орондоо буцаж ирэхэд шаардлагатай бүх талын туслалцаа тухайлбал, тухайн улс оронд аюулгүй байдлаа хамгаалуулах, хамгаалах байр, замын зардал, бичиг баримт, виз, оршин суух хугацаа хэтэрсэн асуудал, хуулийн ямар нэгэн асуудалтай холбоотойгоор ханддаг.

Гэхдээ тэд ХХГХ-т өртөхөд хүргэж буй үндсэн шалтгаан болох хувь хүн, банк, ББСБ, ломбардад тавьсан өр зээл, гэмт хэрэгтнүүдийн зүгээс учруулах байнгын өрийн дарамт, өдөр тутмын амьдралаа хэвийн үргэлжлүүлэх санхүүгийн эх үүсвэргүй, ажилд орохыг хүсэвч мэргэжил, боловсролгүй, тогтвортой ажлын байр олдохгүй зэрэг санхүүгийн шалтгаан болоод ар гэрийн зүгээс ирэх дарамт, шахалт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг гэр бүлийн шалтгаан эсвэл орон гэргүй юм уу бусад хүнд нөхцөлд амьдардаг зэрэг ахуйн асуудлаа тэр бүр ил гаргадаггүй.

### 4.1.2. Цагдаагийн байгууллага хохирогчийг илрүүлэх

Судалгаанд хамрагдсан 20 хохирогчоос шууд цагдаагийн байгууллагад хандсан тохиолдол алга. Цагдаагийн байгууллага нь ихэнхдээ нэгдсэн арга хэмжээний үр дүнд ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэн хохирогчоор тогтоодог байна. Тухайлбал, 2018 онд ЦЕГ-с нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг саун, массажны 39 газрыг илрүүлсэн байна. Шалгалтын үеэр давхардсан тоогоор 42 удаа үзлэг зохион байгуулахад насанд хүрээгүй зургаа, насанд хүрсэн 145 эмэгтэйг бэлгийн мөлжлөгийн зорилгоор зохион байгуулалттайгаар бусад биеийг нь үнэлүүлж байсныг илрүүлжээ<sup>22</sup>.

<sup>22</sup> ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Г.Давааням, “Саун, массаж нэрийн дор насанд хүрээгүй охидын биеийг үнэлүүлж байна” ярилцлага, <http://www.mnb.mn/i/134112>.

## Шигтгээ 2.

Судалгаанд хамрагдсан хохирогчдоос цагдаагийн байгууллагад шууд хандаагүй шалтгааныг тодруулахад гэмт хэрэгтнүүд байнга “Та нарт цагдаа итгэхгүй, би цагдаад том артай, цагдаад баригдвал чи шоронд орно, торгуулна, чамайг янхан гээд хэвлэлээр гаргана, эцэг эх, нөхөр, найз залуу, хадам, багшийг чинь дуудаад биеэ үнэлэгч гэдгийг чинь хэлнэ” гэх мэтээр заналхийлдэгт үнэмшиж цагдаагаас холхон байхыг хичээдэг болжээ.

### 4.1.3. Хохирогчийн ар гэрийнхэн хандах

Хохирогч гэр бүлийнхэнтэйгээ удаан хугацаагаар холбогдохгүй, сураггүй болсон, эсвэл гэр бүлийнхнээсээ тусламж хүссэн тохиолдолд ар гэрийнхэн нь төрийн болон ТББ-д ханддаг. Тэд хохирогчдод тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд доорх тусламж үйлчилгээг ихэвчлэн хүсжээ.

#### Зураг 7. Хохирогчийн ар гэрийнхэн хандах



### 4.1.4. Хохирогчийн найз нөхөд, танил тал нь хандах, хандуулах

Судалгаанд хамрагдсан хохирогчдын тав нь найз нөхөд, танил талынхаа дэмжлэгтэйгээр тусламж, үйлчилгээнд хамрагдаж чаджээ. Хохирогчид ихэнхдээ асуудлаа гэр бүлийнхнээсээ нууцлан найз нөхдийн тусламж, дэмжлэгтэйгээр даван туулах, шийдвэрлэхийг оролджээ.

### 4.1.5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд хандуулах

Хүний эрх, эмэгтэйчүүд, хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн болон ТББ-ууд хохирогчийг илрүүлэх, тэднийг энэ чиглэлээр ажилладаг байгууллагуудад холбон зуучлахад гол үүрэгтэй. Судалгаанд хамрагдсан насанд хүрээгүй хохирогчдын дөрвийг нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хорооны нийгмийн ажилтан, багш нар хандуулжээ.

#### 4.1.6. Хууль хяналтын байгууллагын ажилтнууд хандуулах

Цагдаагийн байгууллагын ажилтнууд хохирогчийг хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэхэд шаардлагатай үйлчилгээнд хамруулахаар ТББ-уудтай хамтран ажиллаж байна. Тухайлбал, хохирогчдын дийлэнх нь өмгөөллийн зардлаа гаргах боломжгүй байдгаас ихэнхдээ ТББ-аас туслалцаа, үйлчилгээ авдаг.

**Зураг 8.** Хууль хяналтын байгууллагад хандсан хохирогчдод шаардлагатай туслалцаа, үйлчилгээ

#### Цагдаа, хууль хяналтын байгууллагын ажилтнууд хандуулах



#### 4.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй туслалцаа, үйлчилгээ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлж буй туслалцаа, үйлчилгээний талаар төрийн болон ТББ-ын төлөөлөл нийт 30 ажилтантай ярилцлага хийж, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

#### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээг үнэ төлбөргүй байхаар хуульчилсан байна. Хохирогчид үзүүлэх таван төрлийн үйлчилгээ байх ба тэдгээр үйлчилгээтэй холбоотой журмыг холбогдох төрийн байгууллага батлан гаргах зохицуулалттай. Энэ дагуу холбогдох төрийн байгууллагуудаас таван журам батлагдан гарсан бол хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гаргах ёстой Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, Улсын ерөнхий прокурортой хамтран гаргах хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам<sup>23</sup> өнөөг хүртэл батлагдаагүй байна.

<sup>23</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, 5.2.3-р зүйл <https://www.legalinfo.mn/law/details/554>.

**Хүснэгт 3.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр төрийн захиргааны төв байгууллагуудаас баталсан журмууд

№	Журмын нэр	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	Батлагдсан хугацаа, журмын дугаар	Журмын агуулга
1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх	5-р зүйл: 5.3.2. 12-р зүйл: 12.1.5. 12.2. дахь заалт	Гадаад харилцааны сайдын тушаал 2013.11.15 Дугаар А/91	Хилийн чанадад хүн худалдаалах болон бусад төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэний аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг хамгаалах, эх оронд нь буцаах хүртэлх хугацаанд Дипломат төлөөлөгчийн газраас түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах зэрэг хуульд заасан бусад үйлчилгээг үзүүлэхээр зохицуулсан.
2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх	5-р зүйл: 5.5.1. 5.5.2. 12-р зүйл: 12.1.1. 12.1.2. 12.2. дахь заалт	Эрүүл мэндийн сайдын тушаал 2013.12.09 Дугаар А\462	ХХГХ-ийн хохирогч болсон, сэтгэлзүйн цочмог болон архаг хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэгт өртсөн өвчтөнд сэтгэцийн эрүүл мэндийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэхийг зохицуулсан.
3	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх	12-р зүйл: 12.1.3. 12.2. дахь заалт	Хөдөлмөрийн сайдын тушаал 2015.07.09 Дугаар А/135	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа ХХГХ-ийн хохирогчийг, онцгой тохиолдолд хохирогчийн хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангах ажлыг Тахарын албатай хамтран зохион байгуулахаар журамласан.
4	Урамшуулал олгох журам	16-р зүйл: 16.3.4. 16.5. дахь заалт	Хууль зүйн сайдын тушаал 2016.01.11 А/08	ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр идэвхтэй, үр дүнтэй ажиллаж байгаа байгууллага, хувь хүнийг урамшуулах талаар зохицуулсан.

5	Хүүхдийг Монгол сын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам	5-р зүйл: 5.8. 5.8.1. 5.8.2. 5.8.3. дахь заалт	Хууль зүйн сайдын 2017.03.03 А/49 (2020 оны А/96 тушаалаар өөрчлөн найруулсан)	Монгол Улсын иргэн 18 нас хүртэлх хүүхдийг хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцаа, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан гадаадад зорчиж буй иргэний холбогдох мэдээллийг нягтлан шалгах асуудлыг зохицуулсан. 2020 онд журамд нэмэлт өөрчлөлт оруулан найруулж, холбогдох маягтуудыг баталсан.
6	Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам	12-р зүйл: 12.1.4. 12.2. дахь заалт	Батлагдаагүй	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
7	Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам	5-р зүйл: 5.2.3. дахь заалт	Батлагдаагүй	Улсын ерөнхий прокурортой хамтран Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар бүлэг буюу Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны арга хэлбэрт хохирогч хамгаалал, тэдэнд туслалцаа үзүүлэхэд шаардлагатай журмыг батлан гаргах харилцааг зохицуулсан байна. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний нэг төрөл болох хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар баталж, мөн түүний шийдвэрээр ТББ-д хариуцуулахаар зохицуулсан боловч өнөөгийн байдлаар энэхүү журмыг баталсан Засгийн газрын шийдвэр гараагүй байна.

Харин хохирогчийг хамгаалах, туслалцаа үйлчилгээ үзүүлэх чиглэлээр дараах гурван стандартыг батлан гаргаснаас хоёр нь хүчинтэй хэвээр байна.




1. 2009 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS6040:2009) – ийг батлан гаргасан. Стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хохирогчийг хамгаалах байр ажиллуулах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний жишиг тогтооход оршино. Энэ стандартыг 2019 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилттэй холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулан баталсан тул энэ стандартыг хүчингүй болгож, шинэчилсэн стандартыг (MNS 6040:2019) дагаж мөрдөж байна.
2. 2013 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг

шаардлага” (MNS 6418:2013)-ийг баталсан. Стандартын зорилго нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх олон нийтэд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд оршино. Энэ стандартад ХХГХ-ийн хохирогчийг тогтоох маягт, хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээний үе шатуудад тавигдах шаардлагыг тогтоосон.

3. 2019 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6040:2019)<sup>24</sup> –ийг MNS 6040:2009-ийн оронд дагаж мөрдөхөөр батлан гаргасан. Стандартын зорилго нь хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалан байрлуулах байр ажиллуулах, тэдний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, хэм хэмжээг тогтоож мөрдүүлэхэд оршино. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хохирогчийг хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааг хүний эрхэд суурилан зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, үйлчилгээний явц, чанар, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд хяналт тавих, үнэлэх, магадлан итгэмжлэхэд хэрэглэнэ.

“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартад хохирогчид үзүүлэх үндсэн үйлчилгээг тодорхойлж, үйлчилгээнд баримтлах зарчим, үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавих нийтлэг шаардлага, хохирогчид үйлчилгээ үзүүлэх байр, орон зайн орчин зэргийг тодорхой зааж өгсөн. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний дөрвөн үе шатыг тодорхойлж, хохирогчид заавал үзүүлэх үндсэн үйлчилгээг хэрхэн үзүүлэх, болон үйлчилгээний үе шатуудад кейс менежмент хийх үйл ажиллагааг нарийвчлан тогтоож өгснөөрөө онцлогтой баримт бичиг болсон.

### Зураг 9. Хохирогчид үзүүлэх үндсэн үйлчилгээ

	<p>Зөвлөгөө өгөх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Хохирогч эргэн хэвийн амьдралдаа ороход нь нөлөөлөх</li> <li>• Аливаа тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх</li> </ul>
	<p>Эрүүл мэндийн үйлчилгээ</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулах</li> <li>• Шаардлагатай тохиолдолд хохирогчийг холбогдох эмнэлгийн байгууллагад хандуулах</li> </ul>
	<p>Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйлчилгээ үзүүлэх бүхий л хугацаанд хохирогчид сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх</li> <li>• Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн эмнэлгийн байгууллагад хандуулах</li> </ul>

<sup>24</sup> <https://estandard.gov.mn/standard/reader/2740>





#### Хуульзүйн туслалцаа

- Тухайн хохирогчийн эрүүл мэнд, сэтгэлзүйн нөхцөл байдлын үнэлгээн дээр суурилан өгөх
- Хуулийн зөвлөх хохирогчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гэрч хохирогчийн эрх үүрэг, аюулгүй байдлын хамгааллын талаар мэдээлэл өгөх
- Өмгөөлүүлэх эрхийн талаар бодит мэдээлэл өгөх

Гэвч энэ стандартад хэрэгжилтийг хангах, хяналт тавих байгууллагыг тодорхойлж өгөөгүйгээс цөөн ТББ үйл ажиллагаандаа хэрэглэхээс хэтрэхгүй байгаад анхаарах шаардлагатай байна. Энэ стандарт бодитоор хэрэгжиж эхэлбэл хохирогч төвтэй хандлага, хохирогчид ээлтэй, чирэгдэл, тасалдал, хийдэлгүй үйлчилгээ төлөвшихөд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

### ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

2000 оноос өмнө Монгол Улсад ХХГХ, бэлгийн мөлжлөгийн хохирогчид зориулсан туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг ТББ байгаагүй. Энэ асуудлаар олон нийтийн ойлголт, мэдлэг ч бага байлаа. Тухайн үед энэ чиглэлээр үйл ажиллагаагаа эхэлж байсан Хүний Эрх Хөгжил төв, Хүйсийн Тэгш Эрх Төв ТББ-уудыг дурдаж болох юм.

Нийгэмд энэ асуудалд өртсөн хохирогчдын тоо нэмэгдэхийн хэрээр тусламж, үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагууд бий болж, одоогоор энэ чиглэлээр 10 орчим үндэсний болон олон улсын ТББ-ууд ажиллаж байгаа. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод тусламж, үйлчилгээг анх төрийн бус байгууллагууд хүргэж эхэлсэн бөгөөд одоо ч энэ үйл ажиллагааны хэрэгжилтэд гол байр суурийг эзэлсээр байгаа.


Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ууд нь өөр өөрсдийн зорилго, зорилтдоо тулгуурлан хохирогч хамгааллын асуудлаар мэргэшин ажиллаж байна. Бусад улсад ч гэсэн дийлэнхдээ ТББ-ууд нь хохирогчид үйлчилгээ үзүүлдэг туршлага бий.

Хохирогчид мэргэжлийн, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхийн ач холбогдол нь тэдэнд асуудлаа даван туулах боломж олгох хэвийн амьдралдаа эргэн орох, нийгэмшихэд нь туслах зорилготой. Нөгөө талаар ХХГХ-ийг бууруулах, таслан зогсооход чухал нөлөөтэй юм. Монголын ТББ-уудын хохирогч хамгааллын үйлчилгээ одоогийн түвшинд хүрэхэд олон улсын байгууллагууд (ОУШХБ, АС, FDG гэх мэт.) санхүүгийн хувьд удаан хугацаанд, тогтвортой дэмжиж, хамтарч ажилласан. Одоо ч ТББ-ын хохирогч хамгааллын үйл ажиллагааны дийлэнх санхүүжилт нь энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ОУБ-уудаас хамааралтай байна.

Төрийн бус байгууллагуудын (ХТЭТ, ЭКПАТ Монгол, Талита Ази, Анбаунд Монгол) ХХГХ, бэлгийн мөлжлөгийн хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлэх механизм нь хохирогчийг олж, тодорхойлсны дараа дор дурдсан хоёр чиглэлээр хэрэгжиж байна.



## Зураг 10. Төрийн бус байгууллагын хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ



Дээрх туслалцаа, үйлчилгээ нь эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө, аюулгүй байдлыг хангахаас эхлээд бие даан хэвийн амьдралдаа эргэн орох хүртэл үргэлжилдэг. Үйлчилгээний үргэлжлэх дундаж хугацаа нь хамгийн багадаа гурван сар, хамгийн ихдээ 24 сар хүртэл байдаг. Гэхдээ анхан шатны туслалцаа, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээг цогцоор нь тогтвортой үзүүлдэг байгууллага цөөн. Тухайн байгууллага нь хохирогчдод шаардлагатай үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх боломжгүй тохиолдолд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад холбон зуучилдаг. Хохирогчдод дараах байдлаар үйлчилгээ үзүүлж байна.

## Зураг 11. Кейс менежмент хийх үйл явц



“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч ТББ-ууд дагаж мөрддөг. Гэхдээ үйл ажиллагаа нь энэ стандартын шаардлагад нийцэж буй эсэхэд хийсэн хяналт, үнэлгээ одоогоор байхгүй байна.

### 4.3. Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төрөл, үе шат

#### 4.3.1. Анхан шатны туслалцаа, үйлчилгээ

Энэ хэсэгт төрийн болон ТББ-ууд хохирогчийг тогтоох, таних, илрүүлэхээс эхлэн хохирогчид ямар төрлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлж буйд дүн шинжилгээ хийж харуулахыг зорилоо. Ялангуяа хууль, журмаар хүлээсэн үүрэг, тэдгээрийн хэрэгжилт, хохирогч төрөөс шууд авахаар заасан үйлчилгээнээс ямрыг авч, эсвэл авч чадахгүй байгааг тогтоохоор ажиллалаа. Хэдийгээр холбогдох хуулиудыг даган гарах журмуудын дийлэнх нь батлагдсан боловч хэрэгжилт хангалттай бус, хохирогч төрөөс үнэ төлбөргүй, цаг алдалгүй үйлчилгээ авах боломж хязгаарлагдмал хэвээр байна. Энэ орон зайд цөөн ТББ-ууд ажилладаг хэдий ч санхүүгийн тогтвортой эх үүсвэргүйгээс шалтгаалан хохирогчид цогц үйлчилгээ үзүүлэх боломж хомс байгаад анхаарлаа хандуулах шаардлагатай.

### 4.3.1.1. Хохирогчийг таньж мэдэх, илрүүлэх, тогтоох

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж мэдэх, илрүүлэх, тогтоох үйл явц нь тэдэнд туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны хамгийн чухал хэсгийн нэг юм. Хохирогчоо зөв тогтоосноор гэмт хэргийг таслан зогсоож, бусад хохирогчдыг аврах, цаг алдалгүй туслалцаа үзүүлэх боломж нээгддэг. ХХГХ-ийн хохирогчийг тогтоох үйл ажиллагааг нэгдсэн загварт оруулах нь зөвхөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бус хохирогч, түүний гэр бүлийнхэнд хохирогч болсон эсэхээ нийтлэг шалгуураар таньж мэдэж, тодорхойлох боломж олгодог. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, УДШ-ийн тайлбаруудад ХХГХ-ийн тодорхойлолт нэгдсэн байдлаар тусаагүй тул аливаа байгууллага, ажилтан өөрийн сонгосон хуулийн хүрээндээ хохирогчийг тодорхойлж байгаа бол ТББ, ОУБ-ууд тус бүрдээ хохирогчийг тодорхойлох өөр өөр хувилбартай байна. Хэдийгээр ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх стандартад хохирогч тогтоох маягтыг баталгаажуулсан боловч хэрэглэх хүрээ нь хязгаарлагдмал тул орон даяар нэгдсэн журмаар хэрэглэх боломжгүй байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох шийдвэр гаргах ба хохирогч нь хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.” гэж заасан.

**Зураг 12.** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, тогтоох



Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, түүнийг дагаж гарсан журмуудад ХХГХ-ийн хохирогчийг тогтоох маягтыг тусгайлан тусгаж өгөөгүй учраас хуулийн ойлголтын хүрээнд хохирогчийг тогтоодог. Хэдий Хүн худалдаалах гэмт

хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээний стандартын<sup>25</sup> хавсралтаар хохирогчийг тогтоох маягтыг баталгаажуулсан ч зөвхөн ТББ хэрэглэхээр хязгаарласан тул хуулийн байгууллагууд албан ёсоор хэрэглэх боломжгүй юм.

Харин хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон тохиолдолд Гадаад хэргийн сайдын 2013 оны А/91 дүгээр тушаалын хавсралт журмын 3.1. дэх хэсэгт “Гэмт хэргийн хохирогч болсон нь тухай улсын холбогдох эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээлэл, тодорхойлол болон иргэний гаргасан өргөдөл, шаардлагатай гэж үзвэл гэрчийн мэдүүлгээр нотлогдсон тохиолдолд ДТГ-ын тэргүүн, түүний эзгүйд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хохирогчийг хүлээн авч, түр хугацаагаар орон байраар хангах асуудлыг шийдвэрлэнэ.”, мөн журмын 3.3 дахь хэсэгт “суугаа орондоо болон хавсран суух, хавсран хариуцах улсад нь хохирогч болсон нь тогтоогдсон иргэний талаар мэдээллийг ГХЯ-ын Консулын газарт 24 цагийн дотор мэдэгдэнэ.” гэж заасан байдаг.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Хүн худалдаалах гэмт хэргийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон ТББ-ууд нь туслалцаа, үйлчилгээ хүсэж хандаж ирсэн үйлчлүүлэгчтэй тус бүр өөрсдийн дотооддоо баталсан тусгай маягтын дагуу ярилцлага, үнэлгээ хийж, хохирогч болсон эсэхийг тогтоодог.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эсэхийг зөв тогтоож, тодорхойлсноор үйлчлүүлэгч бүрийн онцлог, нөхцөл байдалд тохирсон үйлчилгээг төлөвлөж, хэрэгжүүлэх боломж бүрдэх юм. Гэвч Монгол Улсад төрийн болон ТББ, мэргэжилтэнд зориулсан ХХГХ-ийн хохирогч тогтоох агуулга бүхий нэгдсэн заавар, журам, маягт байхгүй байна. Иймээс байгууллагууд иргэнтэй ярилцлага хийж, хохирогч болсон байх эрсдэл ажиглагдвал хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад холбон зуучилж, харин тухайн байгууллага нь өөрсдийн дагаж мөрддөг маягтын дагуу хохирогчийг тодорхойлж, үйлчилгээнд хамруулж байна.

### Шигтгээ 3.

*Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ нь БНСУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид тусалцаа үзүүлэх” төслийг 2019 оноос эхлэн таван жилийн хугацаатайгаар хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогчийг тогтоох, илрүүлэх удирдамж боловсруулж байна. Энэхүү төсөл хэрэгжих хугацаанд энэ төрлийн хохирогчтой ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагууд хохирогчийг тогтоох, илрүүлэх нэгдсэн удирдамжтай болж, энэхүү хүлээн зөвшөөрөгдсөн, батлагдсан баримт бичгийг үйл ажиллагаандаа хэрэглэх боломж бүрдэх юм...*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

<sup>25</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, <https://estandard.gov.mn/standard/v/3667>.

Гэхдээ энэхүү удирдамж нь бэлгийн мөлжлөгийн хохирогчийг тогтоох зорилготой тул цаашид ХХГХ-ийн бусад төрөлд өртсөн хохирогчийг тогтоох удирдамж боловсруулах хэрэгцээ, шаардлага бий. Мөн байгууллага бүр өөр өөр хохирогч тогтоох аргачлалтай байгаа нь цаашид хохирогчийг таньж тогтоох, илрүүлэхэд хийдэл, зөрчил бий болгох эрсдэлтэй тул улсын хэмжээнд дагаж мөрдөх ХХГХ-ийн хохирогчийг таних шалгуур үзүүлэлтийг батлан гаргаж, дагаж мөрдүүлбэл бодит үр дүн хүрнэ.

#### **4.3.1.2. Эх оронд нь эгүүлэн авчрах үйлчилгээ**

Хүн худалдаалах гэмт хэрэг нь дотоодод төдийгүй хилийн чанадад үйлдэгддэгээрээ бусад гэмт хэргээс онцлогтой. Тиймээс хохирогчид нэн шаардлагатай чухал үйлчилгээний нэг нь худалдаалагдаж, мөлжлөгт өртсөн улсаас нь эх оронд нь эгүүлэн авчрах байдаг. Энэ үйлчилгээ нь зардал өндөр, гадаад, дотоодын төрийн болон ТББ-уудын хамтын ажиллагааг шаарддаг. Тухайлбал, хохирогчийг буцаан авчрах аяллын зардал, тэтгэмж, бичиг баримт, визний асуудлыг шийдвэрлэх, аюулгүй байдлыг хангах, аялахад нь үйлчлүүлэгчийг бэлдэх гэх мэт. Энэ асуудлыг улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрхэн шийдвэрлэх талаар Палермогийн протоколд тусгайлан заасан байдаг бөгөөд Монгол Улс нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульдаа хилийн чанадад хохирогч болсон иргэдэд хэрхэн туслалцаа үзүүлж, эх орондоо авчрах талаар тусгаж, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тусгайлсан журам гаргаж, дагаж мөрдөхөөр зохицуулсан байна. Хэдийгээр ХХТгХ-ыг дагаж гарсан журмын дагуу ГХЯ нь хохирогчийг эх орондоо эгүүлэн авчрах үйл ажиллагааг бүрэн зохион байгуулж, холбогдох зардлыг Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас гаргахаар журамласан ч уг сангийн журамд зааснаар <sup>26</sup> ХХГХ-ийн хохирогч тусламж авах ангилалд багтаагүй юм. Өөрөөр хэлбэл ГХЯ-аас тус тус баталсан Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн журам<sup>27</sup> нь Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх журамтайгаа нийцээгүй тул одоо ч хилийн чанадад буй ХХГХ-ийн хохирогчийг эх орондоо буцаан авчрах зардалд ОУБ-ын дэмжлэг авсан хэвээр байна.

### **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар хилийн чанадад хохирогчдод шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлэх ажлыг ГХЯ болон тухайн улс оронд суугаа ДТГ зохион байгуулах бөгөөд эдгээр үйл ажиллагаанд шаардлагатай зардлыг Засгийн газрын дэргэдэх Иргэдэд туслах сангаас гаргах журамтай.

<sup>26</sup> "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан"-гаас Монгол Млсын иргэнд дараах тохиолдолд тусламж, зардал олгоно", <https://consul.mn/index.php?moduls=6>. (сүүлд үзсэн: 2021.09.20).

<sup>27</sup> Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн дүрэм, <https://www.legalinfo.mn/annex/details/8533?lawid=13508>.

Гэхдээ энэ хүрээнд хэдэн хохирогчийг нутагт нь эгүүлэн авчирсан, туслалцаа үзүүлсэн талаарх мэдээлэл байсангүй<sup>28</sup>.

2019-2020 оны байдлаар хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон Монгол Улсын иргэдийг эх оронд нь эгүүлэн авчрах үйл ажиллагааг төрийн болон ТББ, ОУБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн байна.

**Хүснэгт 4.** Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид туслалцаа үзүүлэх<sup>29</sup> журмын товч танилцуулга

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээнд хамрагдах үндэслэл	Хэрэгжүүлэгч болон үүрэг хүлээсэн байгууллага	Санхүүжилт
Хилийн чанадад хүн худалдаалах болон бусад төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон МУ-ын иргэний аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг хамгаалах эх оронд нь буцаах хүртэлх хугацаанд Дипломат төлөөлөгчийн газраас түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах үйлчилгээ	Гэмт хэргийн хохирогч болсон нь тухай улсын холбогдох эрх бүхий байгууллагаас өгсөн мэдээлэл, тодорхойлолт болон тухай иргэний гаргасан өргөдөл, шаардлагатай гэж үзвэл гэрчийн мэдүүлгээр нотлогдсон тохиолдолд ДТГ-ын тэргүүн, түүнийг эзгүйд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр хохирогчийг хүлээн авч, түр хугацаагаар орон байраар хангах асуудлыг шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн эмч, сэтгэл зүйч, өмгөөлөгчийн тусламж үзүүлж болно.	ГХЯ нь ХХТХ-ийн 5.3.1, 5.3.2, 11.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	Гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн аюулгүй байдлыг хангах, тэдэнд үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг Иргэдэд туслах сангаас гаргана.

#### **Шигтгээ 4.**

*Гадаадад ХХГХ-т өртсөн байх магадлалтай хохирогч илэрсэн тохиолдолд шууд ТББ-тай хамтран ажилладаг. Албаны шугамаар хандахаар маш удаан хугацаа шаарддаг, мөн хохирогчийг эх оронд нь авчрахад төсөв, санхүүгийн асуудал шийдвэрлэгдэхэд хүнд. Тиймээс бид мэргэжлийн байгууллагатай түлхүү хамтран ажилладаг.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

<sup>28</sup> Иргэдэд туслах сангийн зарцуулалтын тайлан /2020/, <https://www.consul.mn/index.php?moduls=83>.

<sup>29</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам, Гадаад хэргийн сайдын А/91-р тушаал, <https://www.legalinfo.mn/law/details/10604?lawid=10604>.

Дэлхий нийтийг хамарсан “КОВИД-19” цар тахлаас үүдэлтэй хөл хорионы хатуу дэглэмийн үед Хүйсийн тэгш эрхийн төв гол зохион байгуулалтыг хариуцан, ГХЯ-ны Консулын хэлтэс, ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэлтэс, ХЗДХЯ-ны ГХУСАЗЗ, ОУШХБ, Азийн сан зэрэг байгууллагуудын санхүүгийн дэмжлэгтэйгээр ГХУСАЗЗ-ын дэргэдэх Хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох Дэд зөвлөл, ЦЕГ-ын Хүн худалдаалахтай тэмцэх тасаг, Тагнуулын ерөнхий газар, Улсын онцгой комисс, Тайланд улсад суугаа ЭСЯ, Малайз улс дахь өргөмжит консулын газруудтай нягт хамтран ажилласан нь үр дүнгээ үзүүлжээ.

- Нэг хохирогчийг эх нутагт нь эгүүлэн авчрах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг тооцон үзэхэд нислэгийн зардал харилцан адилгүй (Малайз улсаас – БНСУ - Монгол Улс гэсэн маршрут), нэг хүн нь ойролцоогоор 1,995,000-4,850,000 төгрөг болж байв. Цар тахлын үед хилийн чанадаас эх нутагтаа эгэн ирж буй хүн бүрийг 21 хоногийн хугацаатай тусгаарлах байранд байрлуулсны төлбөрт нэг хүнд 1,050,000<sup>30</sup> төгрөг зарцуулжээ.<sup>31</sup>
- Гадаад хэргийн яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Ажлын алба нь улсын төсвийн хөрөнгөөр гурван хохирогчийн нислэгийн, найман хохирогчийн тусгаарлалтын байрны зардлыг гаргасан.<sup>32</sup> Гэхдээ үүнийг Иргэдэд туслах сангаас гаргасан эсэх талаар тодорхой мэдээлэл байхгүй байна.

---

### **Шигтгээ 5.**

*Үйлчилгээнд тусгайлсан төсөв хөрөнгө байдаггүй. Төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлэх болоод Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хохирогч хамгааллын үйлчилгээнд жил бүр тодорхой төсвийг хуваарилан зарладаг болсон. 2020 онд 30 000 000 төгрөгийг Хохирогч хамгааллын үйл ажиллагаанд хуваарилж, гэрээлэгч байгууллагаар Хүйсийн тэгш эрх төв шалгаран хэрэгжүүлсэн.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

НҮБ-ын ОУШХБ нь найман хохирогчийн нислэг болон тусгаарлах байрны зардлыг гаргасан. Тус байгууллага нь 2007 оноос эхлэн Хүйсийн тэгш эрх төвтэй хамтран хилийн чанадад буй хохирогчийг эх нутагт нь эгүүлэн авчрах ажлыг зохион байгуулсан туршлагатай.

<sup>30</sup> 2020.03.26-ны Улсын онцгой комиссын шийдвэрээр 14 хоногийн тусгаарлалтыг 21 хоног болгон нэмэгдүүлж тусгаарлалтын зардал 1,050,000 төгрөг болсон., <https://montsame.mn/mn/read/220243>, (сүүлд үзсэн: 2021.09.20).


<sup>31</sup> Хүйсийн тэгш эрх төв ТББ-аас Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлсэн мэдээлэл, 2021 он, Улаанбаатар хот.

<sup>32</sup> Дэд зөвлөл, “Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт”, 2021 он, Улаанбаатар хот.

ХНХЯ нь Хүйсийн тэгш эрх төвтэй хамтран БНСУ-ын Засгийн дэмжлэгтэйгээр “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийг хэрэгжүүлж, уг төслийн хүрээнд хоёр хохирогчийн нислэг, дөрвөн хохирогчийн тусгаарлалтын зардлыг гаргасан байна.

2020 оноос эхлэн Азийн сан нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлж эхэлсэн ба хилийн чанадаас хохирогч эгүүлэн авчрах үйл ажиллагааг дэмжсэн. Тухайлбал, таван хохирогчийн нислэгийн зардлыг гаргахын зэрэгцээ Малайз Улсад ХХГХ-ийн хохирогч болсон иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах зорилгоор өмгөөллийн үйл ажиллагаанд 5,000,000 төгрөгийн дэмжлэгийг Хүйсийн тэгш эрх төвд үзүүлсэн.<sup>33</sup>

**Зураг 13.** 2020 онд ХХГХ-ийн хохирогчдыг эх орондоо эгүүлэн авч ирэхэд үзүүлсэн санхүүгийн туслалцаа (байгууллагаар)



## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Монгол Улсад анх удаа ОУШХБ-ын техникийн болон санхүүгийн дэмжлэгт тулгуурлан хохирогчийг аюулгүйгээр эх оронд нь эгүүлэн авчрах аргачлалыг нэвтрүүлэн 2007 оноос эхлэн Хүйсийн тэгш эрхийн төв нь төрийн байгууллагуудтай (ГХЯ, Дипломат төлөөлөгчдийн газрууд, ЭЦА гэх мэт) хамтран хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл энэ зарчмаар үйлчилгээ үзүүлж байна. Хохирогчийг эх оронд нь буцаан авчрах зардлын эх үүсвэр тогтвортой биш

<sup>33</sup> Хүйсийн тэгш эрх төв, ганцаарчилсан ярилцлага, 2021 он.



хүчир туслалцаа хүссэн хүн бүрийг энэ үйлчилгээнд хамруулахад бэрхшээлтэй. Тиймээс ХХГХ-ийн хохирогчийг тогтоох маягтын дагуу ярилцлага хийж, эрсдэлийн түвшинг үнэлэн үзсэний дараа шаардлагатай хууль хяналтын болон ТББ-уудад мэдээлэл хүргэж, яаралтай туслалцаанд хамруулах, хамтран ажиллах, санхүүжилтийн эх үүсвэр хайх зэргээр ажилладаг. Мөн илүү олон хохирогчийг туслалцаанд хамруулахын тулд бусад ОУБ-ын дэмжлэгийг авсаар иржээ.

Одоогоор ХХГХ-ийн хохирогчийг эх оронд нь эгүүлэн авчрах үйлчилгээг Хүйсийн тэгш эрхийн төвөөс өөр ТББ үзүүлээгүй байна. Тус байгууллагад энэ асуудлаар үйлчлүүлэгч хандсан тохиолдолд эхлээд хохирогч мөн эсэхийг тогтоож, улмаар эх оронд нь авчрах ажиллагааг төрийн болон ОУБ-тай хамтран зохион байгуулж, ерөнхий зохицуулалтыг ханган ажилладаг юм. Тус төв нь 2006-2020 онд ХХГХ-ийн хохирогч болсон нийт 302 монгол иргэдийг гадаадын 10 улсаас<sup>34</sup> эх нутагтаа амжилттай авчирч, гадаадын гурван улсын<sup>35</sup> 11 иргэнд бүх талын туслалцаа үзүүлэн, эх оронд нь аюулгүйгээр буцаасан байна<sup>36</sup>. Хохирогч сайн дураар, эх орондоо аюулгүйгээр эгэн ирсний дараа үргэлжлүүлэн тус байгууллагын эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах боломжтой.

#### **4.3.1.3. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах**

Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод хууль, тогтоомжоор хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх нь төрийн үндсэн чиг үүргийн нэг болохыг заасан байдаг. Дэлхий нийтээр ХХГХ-ийг бусад гэмт хэргээс онцгойлон авч үзэж, хүний эрхийн зөрчилд тооцдог төдийгүй гэмт хэргийн онцлогоос шалтгаалан хохирогчийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар олон байгууллагуудаас зөвлөмж, санаачилга гардаг. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, биеэ үнэлэхэд тулган хавчих, албадан жирэмслүүлэх, хүчээр засаж хөнгөлөх буюу адилтган үзэж болох бусад хүнд хэлбэрийн бэлгийн аливаа хүчирхийллийг хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцох<sup>37</sup> болсон.

Манай улс хохирогчийн аюулгүй байдлыг хангах Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, түүнийг дагасан есөн журмыг батлан, даган мөрдөж байна. Хуульд аюулгүй байдлын хамгаалалтын есөн төрлийн арга хэмжээ тусган тэдгээрийг хамтатган хэрэглэж болохоор заасан. Мөн шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан. Гэвч хууль тогтоомжийн уялдаа холбоогүй байдлаас шалтгаалан хохирогч хуулийн байгууллагад хандахаас өмнө аюулгүй байдлаа хангуулах боломж хязгаарлагдсан. Өөрөөр хэлбэл Хүн худалдаалахтай

<sup>34</sup> БНХАУ, Турк, Малайз, Макао, БНСУ, Украин, Казакстан, Камбож, Филиппин, Хонг Конг.

<sup>35</sup> Фижи, Филиппин, Мьянмар.

<sup>36</sup> Хүйсийн тэгш эрхийн төвийн мэдээллийн сан, 2003-2020 он.

<sup>37</sup> 1998.7.18-ны өдөр баталж, 2002.7.01-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол улс 2000.12.29-нд нэгдэн орж, 2002.04.05-ны өдөр соёрхон баталсан, <https://www.legalinfo.mn/law/details/1217>.


тэмцэх тухай хуульд эрүүгийн хэргийн хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан туслалцаа авах боломжтойг тусгайлан зааж өгсөн байдаг бол Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиар зөвхөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу эрүүгийн хэрэгт гэрч, хохирогчоор тогтоогдсон үед амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэхээр заасан. Энэ нь эрсдэлтэй нөхцөлд буй хохирогчийг аюулгүй байдлыг бүрэн дүүрэн хангах боломжгүй нөхцөл үүсгэсэн юм. Гэтэл ихэнх тохиолдолд хохирогчид өөрийн болон гэр бүлийн аюулгүй байдлаа хангуулан, эрсдэлээс холдож, аюулгүй, тайван нөхцөлтэй болсны дараа л хуулийн байгууллагад хандах эсэхээ шийдэхийг хүсдэг гэж ТББ-ын ажилтнууд мэдээлсэн.

## **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА**

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.4 дүгээр зүйлд “хохилогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогчийн хамаарал бүхий этгээд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, энэ хуульд заасны дагуу хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалуулах туслалцаа авах хүсэлтийг шүүх, прокурор, мөрдөгчид гаргаж болно.” гэж заасан байдаг.

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэрийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын заасан санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч гаргах ба Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан дараах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг авч болно.

## Зураг 14. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ<sup>38</sup>



Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах шийдвэр гаргахдаа дараах зүйлийг тусгана. Үүнд:

1. Аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ авах;
2. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах хугацаа;
3. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага;
4. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх явцад эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэглэх хуульд заасан албадлага зэргийг нарийвчлан тусгана.

Хууль зүйн сайдын 2014 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журамд<sup>39</sup> зааснаар прокурор, шүүгч, гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ авах шийдвэрийг бичгээр гаргана.

<sup>38</sup> Гэрч хохирогчийг нүүлгэн шилжүүлэх, бичиг баримтыг солих, гадаад төрхийг өөрчлөх тусгайлсан журмуудад чиг үүргийн байгууллагууд нууцын зэрэглэлтэй хэрэгжүүлэх зохицуулсан.

<sup>39</sup> Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, 2017.09.07, 2021.04.08-нд тус тус нэмэлт өөрчлөлт орсон, <https://www.legalinfo.mn/law/details/10464>.

## Шигтгээ 6.

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсээс 2016-2018 онд нийт 262 гэрч, хохирогч, иргэнийг (хамаарал бүхий этгээд, гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн хүн, шүүгч, прокурор) хамгаалалтад авч нийт 179 аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.<sup>40</sup>

Гэрч, хохирогчид зохиомол нэрийг эрх бүхий байгууллагаас өгөх ба гэрч, хохирогч нь уг нэрийг зөвхөн мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаанд оролцох үед хэрэглэнэ. Харин мэдээллийн нууцлалыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцсон төрийн болон ТББ, ААН-ийн д холбогдох албан тушаалтан, алба хаагч, хамгаалуулагчаас нууцын баталгаа гаргуулна. Эрх бүхий байгууллага, албан тушаалтан гэрч, хохирогчид байнгын хяналт тавьж, хамгаалалтын үйл ажиллагааны нууцлалыг хангах тухай журмаар зохицуулсан байна.

**Хүснэгт 5.** Гэрч, хохирогчийг хамгаалах талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үүрэг

Байгууллага	Үүрэг
Засгийн газар	Гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх талаар хөтөлбөр баталж хэрэгжүүлэх; Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд тусгах.
Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Гэрч, хохирогчийг хамгаалах талаар гадаад улстай хэлэлцээр хийх, гэрээ байгуулах; Гэрч, хохирогчийг хамгаалах, тусламж үзүүлэх Үндэсний хөтөлбөрийн дагуу гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх ажлыг уялдуулан зохицуулах.
Шүүх, прокурор, мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Гэрч, хохирогчтой харьцах, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр шүүгч, прокурор, мөрдөгчийг чадвар сайжруулах сургалтад хамруулж, хохирогч, гэрчтэй харьцахад баримтлах журам боловсруулж, баталж мөрдүүлнэ.
Нутгийн өөрөө удирдах болон төрийн байгууллага	Гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Гэрч, хохирогчийг хамгаалах хуульд заасан байгууллага болон эрх бүхий бусад байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлэх

<sup>40</sup> Л.Галбаатар, “Гэрч, хохирогчийн хамгаалалт” бодлогын судалгааны тайлан, 2019 он, Улаанбаатар хот.

---

## **Шигтгээ 7.**

*Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд хохирогчоор тогтоогдсон хүн л орно. Хохирогчоор тогтоогдоогүй бол хамгаалалтад орж чаддаггүй. Хуулийн зөрүүтэй байдлыг арилгах хэрэгцээ байгаа.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

### **4.3.1.4. Хамгаалах байрны үйлчилгээ**

Энэ үйлчилгээний зорилго нь амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь заналхийлэл учирсан хохирогчийг түр хамгаалан байрлуулж, үйлчилгээ үзүүлдэг. Хүйсийн тэгш эрхийн төв нь ШХА, Хүний аюулгүй байдлын судалгааны төв ТББ-ын дэмжлэгтэйгээр 2007 онд ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах байрыг Улаанбаатар хот болон Монгол Улсын өмнөд хилийн боомт Замын-Үүд суманд байгуулсан. Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг ТББ-ууд үйл ажиллагаагаа нэгтгэх зорилгоор ОУШХБ-ын “ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх шууд туслалцааны удирдамж”<sup>41</sup> болон олон улсын, дотоодын сайн туршлагад суурилан төрийн байгууллагуудтай хамтран “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-ыг боловсруулж, 2008 онд НХХЯ-ны Техникийн хороо, 2009 онд СХЗГ баталснаар улс даяар үйл ажиллагаандаа мөрдөж ирсэн<sup>42</sup> байна. Одоогоор манай улсад ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах төрийн байгууллагын тусгай хамгаалах байр байгуулагдаагүй бөгөөд хоёр ТББ-ын урт, богино хугацааны таван хамгаалах байр ажиллаж байна.

## **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, алдар хүндийг хамгаалах, аюулгүй байдлыг нь хангах зорилгоор хамгаалах байр ажиллана. Хохирогч болсон гэж өөрийгөө үзсэн этгээд хамгаалах байрны үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ цагдаагийн байгууллага эсхүл хамгаалах байрны захиргаанд гаргана. Хүн худалдаалах гэмт хэргийг цагдаагийн болон тагнуулын байгууллага шалгаж эхэлсэн эсэхийг үл харгалзан хохирогчийг хамгаалах байранд түр байрлуулна. Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална. Засгийн газрын шийдвэрээр хамгаалах байрны үйл ажиллагааг төрийн бус байгууллагад хариуцуулж болно” гэж заасан. Одоогоор манай улсад ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах төрийн байгууллагын тусгай хамгаалах байр байгуулагдаагүй бөгөөд

---

<sup>41</sup> The IOM: Handbook on Direct Assistance for Victims of Trafficking, <https://publications.iom.int/books/iom-handbook-direct-assistance-victims-trafficking-0>.

<sup>42</sup> Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага: MNS 6040:2009.

ХХГХ-ийн хохирогч хамгааллын үйлчилгээг ТББ-ууд хариуцан гүйцэтгэж байна.

Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журамд зааснаар хамгаалах болон тусгай хамгаалах байр нь тасралтгүй ажиллах ба аюулгүйн нөхцөл, хамгаалалтын техник хэрэгслээр хангагдсан, хүн хүчний хүрэлцэхүйц нөөцтэй, байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх ба зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр зохицуулсан<sup>43</sup>. Гэвч 2007 оноос эхлэн өнөөдрийг хүртэл Хүйсийн тэгш эрх төвийн ХХГХ-ийн хохирогчийн хамгаалах байранд төрөөс 2011 онд таван сая төгрөг, 2012 онд долоон сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн<sup>44</sup> нь тогтмол санхүүгийн эх үүсвэрийн зохицуулалт байхгүйг илтгэж байна.

---

### **Шигтгээ 8.**

*Төрийн байгууллагууд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах байруудыг ажиллуулдаг ч ХХГХ-ийн хохирогчийг авах зохицуулалтгүй. Гэтэл сүүлийн үед зарим ТББ-ын хамгаалах байр нялх хүүхэдтэй, гараад очих газаргүй, удаан хугацаанд байрлах эсвэл 16 насанд хүрээгүй хохирогчийг дотоод журмын дагуу гээд авахгүй байгаа. Шалтгаанаа хүүхэдтэй нь хамт удаан хугацаанд байрлуулах боломжгүй, байрны багтаамж хүрэлцэхгүй гэдэг. Ер нь хүүхэдтэй нь хамт удаан хугацаанд байрлуулах газар нэн хэрэгтэй байгаа.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл “Насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах асуудлыг нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана” гэж заасан.

---

<sup>43</sup> Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам, <https://www.legalinfo.mn/annex/details/11772?lawid=16264>.

<sup>44</sup> Жендерийн үндэсний хороо, “Монгол Улсын Жендерийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж тайлан”, хуудас 63, Улаанбаатар хот.

## Шигтгээ 9.


Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнийг байрлуулдаг түр хамгаалах байранд ХХГХ-ийн хохирогчийг байрлуулах тохиромжгүй. Тэдний хэрэгцээ шаардлага өөр. 2020 онд ХХГХ-ийн нэг хохирогчийг чиглэлийн түр хамгаалах байр луу шилжүүлсэн.

Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг даган гарсан Аюулгүй газарт түр байрлуулах журмаар хохирогчийн эрсдэлийн түвшнээс хамаарч гэрч, хохирогчид төрийн болон ТББ хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэхээр журамласан бөгөөд хууль 2020 онд шинэчлэгдсэнээр тус журам 2021 онд<sup>45</sup> мөн шинэчлэгдэн батлагдсан.

ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь ЭЦГ-ын Хүн худалдаалахтай тэмцэх хэлтсээс хохирогчоор илрүүлсэн иргэний эрсдэлийн үнэлгээг хэрэг бүртгэлтийн болон эрүүгийн хэрэг үүссэн эсэхээс үл хамааран хийх бөгөөд хамгаалах байранд байрлуулах, хамгаалалтад авах бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээж хяналтын прокурорын тогтоолоор хэрэгждэг.

### Зураг 15. Эрсдэлийн түвшинг тогтоох



Уг журамд “эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу зөвхөн эрсдэлийн өндөр түвшинтэй гэрч, хохирогчийг тусгай хамгаалах байранд, эрсдэлийн дунд болон бага түвшинтэй гэрч, хохирогчийг хамгаалах байранд

<sup>45</sup> Аюулгүй газарт түр байрлуулах журам, <https://www.legalinfo.mn/annex/details/11772?lawid=16264>.



тус тус байрлуулна”<sup>46</sup> гэж заасан. Журамд насанд хүрээгүй гэрч, хохирогчид хамгаалалтын арга хэмжээний туслалцаа үзүүлэх тусгайлсан бүлэг оруулсан боловч тусгай хамгаалах байргүйгээс хэрэгжих боломжгүй байна. Цаашид төрийн байгууллагын дэргэд буюу ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах газрыг түшиглэсэн ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах байр байгуулах хэрэгтэй гэсэн саналыг оролцогчид ярилцлагын явцад гаргаж байлаа.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Хамгаалах байр нь хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг түр хугацаанд хамгаалж, үйлчилгээ үзүүлэх зориулалттай. Монгол Улсад ТББ-ын дэргэдэх хамгаалах байранд ХХГХ-ийн хохирогчийг байрлуулж, үйлчилгээ үзүүлж байна.

Гэтэл ТББ-уудын дэргэдэх хамгаалах байр нь хүчин чадал, санхүүжилтийн хэмжээ, ажиллах хүчний нөөц, байгуулагдсан шалтгаалан зэргээсээ хамаараад олон хүнд нэгэн зэрэг үйлчилгээ үзүүлэх боломжгүй. Одоогийн байдлаар хоёр ТББ-ын дэргэд урт, богино хугацааны таван хамгаалах байр ажиллаж, эрсдэлийн түвшнээс үл хамааран ХХГХ-ийн хохирогчдыг байрлуулж байна. Энэ нь тухайн хамгаалах байрны ажилтнууд, бусад үйлчлүүлэгчдийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болзошгүй тул тусгай хамгаалах байрыг төрийн байгууллагын дэргэд яаралтай байгуулах хэрэгцээ хэдийнээ үүссэн. Хамгаалах байрны үйл ажиллагааны зардлын дийлэнх хувь нь ОУБ-уудын Монгол Улсад хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслөөс хамааралтай байна. Тухайлбал, Хүйсийн тэгш эрх төвийн хоёр хамгаалах байрны үйл ажиллагааны зардлыг 2007-2011 он хүртэл ШХА, 2007-2020 оныг хүртэл дунд нь цөөн жилийг алгассан ч боломжит төсөл, төсвийн хүрээндээ ОУШХБ тус хариуцаж хамтарч ажилласан нь хамгаалах байрны тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлжээ.

---

### *Шигтгээ 10.*

*2007 оноос Хүйсийн тэгш эрх төв ТББ, 2014 оноос Талита Ази ТББ ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх хамгаалах байруудыг ажиллуулж байна.*

*Хүйсийн тэгш эрх төв ТББ нь Улаанбаатар хотод (зургаан хүний) болон Дорноговь аймгийн Замын-Үүд суманд (гурван хүний) тус бүр нэг хамгаалах байртай. Нэг удаа 16 болон түүнээс дээш насны есөн хүнийг хүлээн авах боломжтой. Улаанбаатар хотын хамгаалах байрны нэг хүнийг байрлуулах дундаж хугацаа нь 3-6 сар бол Замын-Үүдийн хамгаалах байрыг дамжин өнгөрөх, түр хамгаалах байр хэлбэрээр ажиллуулдаг. Хохирогч хилийн чанадаас эх орондоо ирсний дараа орон нутагт үйлчилгээнд хамрагдаж, үргэлжлүүлэн Улаанбаатар хот дахь хамгаалах байранд түр байрлан үйлчилгээ авах боломжтойгоороо давуу талтай.*

---

<sup>46</sup> Мөн тэнд, 4.2 дугаар заалт.

*Талита Ази ТББ нь Улаанбаатар хотод 15-аас дээш насны хүмүүст үйлчилдэг нийт гурван хамгаалах байртай. Богино хугацаагаар (12 сар) хохирогчдод анхан шатны үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдсан хоёр, үйлчлүүлэгчийг бие даан амьдрахад бэлтгэх зорилгоор урт хугацаанд (24 сар) байрлуулдаг нэг хамгаалах байртай. Бусад байгууллагаас ялгагдах давуу тал нь хамгаалах байрны зардал нь Швед дэх төв байгууллагаас гардаг тул санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхой, тогтвортой юм.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

Дээрх хоёр байгууллагын хамгаалах байранд үйлчлүүлэгчийг байрлуулах дундаж хугацаа, үйлчлүүлэгчийн насны хязгаар, байршил, үйлчилгээний онцлогоос хамааран үйлчлүүлсэн хүмүүсийн тоо нь харилцан адилгүй. Хамгаалах байр нь нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч, эрүүл мэндийн ажилтнаар дамжуулан дараах үйлчилгээг үзүүлж байна.

1. Аюулгүй байдлыг хангах
2. Хоол хүнс, хувцас хангах;
3. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх;
4. Сэтгэл зүйн зөвлөгөө, засал;
5. Хууль зүйн зөвлөгөө өгөх;
6. Амьдрах ухааны сургалт;
7. Бусад.

Одоогоор Монгол Улсад насанд хүрээгүй хүн худалдаалах гэмт хохирогчийг байрлуулах тусгайлсан хамгаалах байр байхгүй.

#### **4.3.1.5. Хууль зүйн туслалцаа**

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын ихэнх нь хууль ёсны эрхээ хамгаалах, хуулийн хүрээнд асуудлаа хэрхэн шийдвэрлүүлэх, тулгарч болох асуудлын талаар ойлголт, мэдлэггүй байдаг. Тиймээс үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь хохирогчид дээрх зорилгоор хууль зүйн туслалцаа үзүүлдэг. Ер нь хохирогчдод тулгардаг гол бэрхшээлийн нэг нь өмгөөлөгчөөр хангуулах эрхээ эдлэх явдал юм. Өмгөөлөгч, үйлчлүүлэгч талууд өмгөөллийн үйлчилгээний хөлсөө гэрээгээр харилцан тохиролцож тогтоодог бөгөөд ХХГХ-ийн хохирогч нь ихэнхдээ төлбөрийн чадваргүй тул өмгөөлөгч хөлсөлж чаддаггүй.

Хэдийгээр Монголын Хуульчдын холбооноос төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг ч иргэдээс төлбөрийн чадваргүй байдлаа нотолсон баримт шаарддаг. Үүнд: Харьяа дүүрэг, хорооны нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсээс амьжиргааны түвшин тогтоосон тодорхойлолт, хөгжлийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт<sup>47</sup> зэрэг бичиг баримтад

<sup>47</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн, "Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тандан судлах судалгааны тайлан", 2017 он, Улаанбаатар хот.

үндэслэн шийдвэрлэдгээс дээрх шалгуурыг хангахгүй эсхүл тодорхойлолт авахын тулд хохирогч хувийн нууцаа задлах, сул доройгоо дахин мэдрэх зэргээр сэтгэл зүйн хувьд дахин хохирох эрсдэлтэй байдаг. Хэдийгээр ТББ-ууд хохирогчид хууль зүйн зөвлөгөө өгөх, өмгөөлөгчөөр хангахад туслалцаа үзүүлэх ажлыг 2007 оноос эхлэн өнөөдрийг хүртэл тасралтгүй гүйцэтгэж байгаа ч хүртээмж хангалтгүй хэвээр байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛАГА

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дүгээр зүйлийн 14 дэх хэсэгт өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулж өгчээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1-р зүйлд “Хохирогч хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно” гэж заасан. Мөн хуулийн 8.2-дугаар зүйлийн 1.1-т хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаажуулсан.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээний төрөлд хууль зүйн туслалцаа үзүүлэх багтсан. Мөн хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар хуульчилсан ч уг журмыг өнөөг хүртэл батлаагүй байна.

### *Шигтгээ 11.*

*Хохирогчдод өмгөөлөгч хэрэгтэй ч үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх газар бараг байдаггүй. Хохирогчид гол төлөв төлбөрийн чадваргүй байдаг учир шууд л ТББ-д хандуулж, өмгөөлөгчөөр хангах туслалцаа хүсдэг. Сэжигтэн, яллагдагчдад өмгөөлөгч үнэ төлбөргүй байдаг хэр нь хохирогчдод байдаггүй.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлээр Цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газрын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байх, түүний дэргэд мэргэжлийн хууль зүйн зөвлөгөө өгөх болон сэтгэл зүйчдийн баг ажиллахаар заасан ч өнөөдрийг хүртэл ажиллаж эхлээгүй байна.

2013 оны “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийн зохицуулалтаар төрөөс хууль зүйн үнэ төлбөргүй туслалцааг зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэхээр хуульчилсан. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн туслалцааны төвийн “Улсын өмгөөлөгч” нь төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.


Дээрхээс харахад ХХГХ-ийн хохирогчийг үнэ төлбөргүй өмгөөлөгчөөр хангах, хууль зүйн туслалцаа үзүүлэх зохицуулалт, тогтолцоо байхгүй байна. Гэтэл ХХГХ-ийн хохирогчид ихэвчлэн эдийн засгийн боломжгүй, эрх зүйн

ямар ч мэдлэггүй байдаг бөгөөд юун түрүүнд тэдэнд хууль зүйн зөвлөгөө өгөх, хохирлоо төлүүлэх талаар нэхэмжлэл гаргуулах, аюулгүй байдлыг нь хамгаалуулах шаардлагатай байдаг. Хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудын дэмжлэгээр зарим хохирогчийг өмгөөлөгчөөр хангадаг ч нийт хохирогчдод хүртээмжгүй байна. Тиймээс хохирогчдод төрөөс үнэ төлбөргүй өмгөөлөгч гаргаж өгөх асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

## ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хууль зүйн туслалцааг дараах байдлаар үзүүлж байна.

**Зураг 16.** Хууль зүйн туслалцааны хэлбэр



Эдгээр байгууллагууд хохирогчдыг мэргэшсэн өмгөөлөгч эсвэл ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад холбон зуучлах байдлаар хууль зүйн туслалцаа үзүүлж байна.

Хүйсийн тэгш эрх төвийн хувьд байгуулагдсан цагаасаа эхлэн ХХГХ-ээр мэргэшсэн өмгөөлөгчдөөр дамжуулан хохирогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллаж буй туршлагатай. Түүнчлэн хуульч, өмгөөлөгчдийг холбогдох агуулгаар чадавхжуулах, жил бүр хуулийн байгууллагын ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалт, бусад үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж ирсэн. Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд хохирогчдод ээлтэйгээр шийдэгдэж буй хэргийн тоо өсөж байна. Энэ нь мэргэшсэн хуульчид болон ТББ-ууд хохирогчид ээлтэйгээр асуудлыг шийдвэрлэхэд тусалж буй практикаар батлагдсан шилдэг туршлага болжээ.

**Зураг 17.** Хохирогч төрийн бус байгууллагаар дамжин хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэх үйл явц

### ХХГХ-ийн хохирогч ТББ-аар дамжин хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэх процесс



#### 4.3.1.6. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ, үйлчилгээ

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан цагаас эхлэн сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ үзүүлэхээр тусгаж, энэ үйлчилгээг ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс хариуцахаар зохицуулсан. Мөн гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг сэтгэл зүйчдийн баг үзүүлэхээр хуульчилсан. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ нь хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдол бүрд сэтгэл зүйчийг байлцуулж, мөрдөн шалгах, шүүх хурлын үйл явцад үүсэх сэтгэлзүйн таагүй байдал, гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилготой. Сэтгэл зүйн зөвлөгөөний гол зорилго нь үйлчлүүлэгчийг дараагийн шатны үйлчилгээг авахад сэтгэл зүйгээр бэлдэх, хувь хүний нөөц, боломжийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд нь туслах, дэмжих зорилготой. Гэвч ихэнх тохиолдолд сэтгэл зүйн хамгаалалт, сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлэх хоёрыг хооронд нь ялгаж ойлгодоггүйгээс хамгаалалтын арга хэмжээг орхигдуулах тохиолдлууд гардаг.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээг эрүүл мэндийн байгууллагууд үзүүлэхээр хуульчилж, салбарын яамнаас зохицуулах журам батлан гаргасан. ХХГХ-ийн хохирогч нь мөлжлөгт өртөж байх үедээ нэг зэрэг олон гэмт хэргийн хохирогч болдгоос маш их айдас, түгшүүр, сэтгэлийн дарамт амсдаг. Үүнийг даван туулахад сэтгэл зүйн зөвлөгөө болон ганцаарчилсан, бүлгийн сэтгэл заслын эмчилгээ, үйлчилгээг тогтвортой үзүүлэх шаардлагатай байдаг. Гэвч сэтгэлзүйн хамгаалалт, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ аль аль нь хангалттай бус, хязгаарлагдмал хэвээр байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12.1.2 дүгээр заалтын дагуу сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ үзүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан гаргах үүрэг хүлээсэн. Эрүүл мэндийн сайдын баталсан журамд<sup>48</sup> ХХГХ-ийн хохирогч болсон, сэтгэл зүйн цочмог болон архаг хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэгт өртсөн өвчтөнүүдэд үнэ төлбөргүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээ үзүүлэхийг бүх шатны эрүүл мэндийн байгууллага, СЭМҮТ-д даалгасан юм. Хохирогчдод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, сэтгэл заслын эмчилгээ хийх, сэтгэцэд нөлөөт эмийн эмчилгээ хийх болон нөхөн сэргээлтийн тусламж үйлчилгээнд энэ журам болон "Өвчний олон улсын Х ангилал"-ыг баримтлан оношилгоо, эмчилгээний батлагдсан стандартуудыг мөрдөж ажиллахаар зохицуулсан ч хэрэгжилт хангалтгүй байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаар сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг гэрч, хохирогчийг сэтгэл зүйн цочролд орохоос сэргийлэх, айдас түгшүүрт автуулахгүй байх зорилгоор авна. Тухайлбал, хамгаалалтад авсан үеэс эхлэн шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах, гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл байдлын талаар болоод шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл байдлын талаар урьдчилан мэдээлэх, шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчийг сэтгэл зүйчтэй хамт байлцуулах зэрэг арга хэмжээ авахаар хуульчилсан байна.

Сэтгэл зүйн үйлчилгээ, сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх Цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар нь гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албаар дамжуулан хэрэгжүүлэхээр зохицуулсан. Дээрх хуулийн зохицуулалтаар Гэрч, хохирогчийг хамгаалах газарт 2020 онд ХХГХ-ийн хохирогч сэтгэл зүйн хамгаалалтын үйлчилгээнд хамрагдаагүй, 2021 оны 7 дугаар сарын байдлаар нэг хохирогчийг хамруулсан байна. Хохирогчид сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ үзүүлэх үйлчилгээ бүрэн утгаараа хэрэгждэггүй. Харин сэтгэлзүйн зөвлөгөө, туслалцаа хэрэгтэй ХХГХ-ийн хохирогчдыг мэргэжлийн ТББ-д хандуулан үйлчилгээнд хамруулдаг байна. Үндсэндээ хохирогчид сэтгэл зүйн хамгаалалт үзүүлэх хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй, хуулийн байгууллагад хандсан цагаас эхлэн хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж дуусах хүртэл хүрч үйлчилж чадахгүй хэвээр байна.

<sup>48</sup> Эрүүл мэндийн сайдын 2013.12.09-нд баталсан "Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай" журам, дугаар 462.

---

## Шигтгээ 12.

*Хохирогчдод сэтгэл зүйн зөвлөгөө, засал маш их хэрэгтэй байна. Сэтгэл зүйн дэмжлэг хэрэгтэй хохирогчдыг мэргэжлийн ТББ, сэтгэл зүйч нартай холбож өгдөг.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

2016 оны 08 дугаар сарын 11-нд Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтад орсон. ЦЕГ-ын даргын 2017 оны А/136 тушаалын хавсралтаар Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн орон тоог баталсан бөгөөд одоогоор нийт 30 албан хаагчтай хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.<sup>49</sup> Тус газарт мэргэжлийн хоёр сэтгэл зүйч ажиллаж байна<sup>50</sup>.

### ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

ТББ нь сэтгэлзүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлдэггүй, зөвхөн сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээг хохирогчдод үзүүлдэг. Сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг хувь хүн, бүлэгт үзүүлэхэд цаг хугацаа, зардал их шаарддаг бөгөөд ТББ-ууд нь (ХТЭТ ТББ, ЭКПАТ Монгол) дийлэнхдээ хохирогчид сэтгэл зүйн анхан шатны мэдээлэл, зөвлөгөө өгч байна. Хэдийгээр тухайн байгууллага болон хамгаалах байранд сэтгэл засалч ажиллуулах хэрэгцээ, шаардлага байдаг ч байгууллагын бодлого ялангуяа ажиллах хүчний нөөц, санхүүжилт зэргээсээ хамаарч орон тооны мэргэжилтэн тогтвортой ажиллуулах нь хүндрэлтэй байдаг. Тиймээс ТББ-ууд нь дийлэнхдээ удаан хугацааны зөвлөгөө, засал шаардлагатай үйлчлүүлэгчийг энэ чиглэлээр мэргэшсэн үйлчилгээ үзүүлдэг мэргэжлийн сэтгэл заслын холбоо, хүрээлэнд холбон зуучилж, төлбөртэй үйлчилгээнд хамруулдаг.

Талита Ази ТББ нь хүн худалдаалах гэмт хэрэг ялангуяа бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд амьдралаа шинээр эхлэх боломж олгоход үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Тус төв нь удаан хугацааны нийгэм сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээг хөтөлбөрийн дагуу тусгай орчинд үзүүлдгээрээ онцлог. Үйлчлүүлэгчдэд урт хугацааны үйлчилгээг (12-24 сар) үзүүлдэг учир үйлчлүүлэгчдийн тоо харьцангуй цөөн байдаг. Тухайлбал, 2014-2020 оныг хүртэл нийт 56 хүнд үйлчилгээ үзүүлжээ.

ЭКПАТ Монгол ТББ нь насанд хүрээгүй хохирогчдод ганцаарчилсан болон бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг үзүүлдэг бөгөөд үйлчилгээний үргэлжлэх дундаж хугацаа 12 сар байна. Жилд дундажаар 25-30 насанд хүрээгүй хохирогчийг үйлчилгээнд хамруулжээ.

---

<sup>49</sup> Л.Галбаатар, “Гэрч, хохирогчийн хамгаалалт” бодлогын судалгааны тайлан, 2019 он, Улаанбаатар хот.

<sup>50</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан”, 2018 он.



Цаашид ТББ-ууд хохирогчдод зориулсан урт хугацааны сэтгэл заслын хөтөлбөрийг турших, хэрэгжүүлэхэд суралцах шаардлага байгааг судалгаанд оролцогчид илэрхийлж байсан. Хохирогчид сэтгэл зүйн зөвлөгөө, засал үзүүлэх төрийн болон ТББ-ын ажилтнуудад зориулсан нэгдсэн хөтөлбөр, удирдамж байдаггүй. Хохирогчтой ажилладаг байгууллагууд үйлчилгээний асуудлаар хоорондоо мэдээлэл, туршлагаа хангалттай хуваалцдаггүйгээс байгууллага бүрийн үйл ажиллагааны талаар хангалттай мэдээлэлгүй, хамтран ажиллах нь бага байна.

#### 4.3.1.7. Эрүүл мэндийн үйлчилгээ

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид бие махбодын болон сэтгэл зүйн хувьд эрүүл, аюулгүй байх нь үйлчилгээг үр дүнд хүргэх хамгийн чухал алхам байдаг. Ялангуяа ХХГХ, бэлгийн мөлжлөгийн хохирогчдын нэн тэргүүний хэрэгцээт үйлчилгээний нэг нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, эмчилгээ юм. Тэд мөлжигдөж байх үедээ бие махбодын, бэлгийн болон сэтгэлзүйн хүчирхийлэл, дарамтад удаан хугацаанд байснаас эрүүл мэндийн хувьд ноцтой хохирч үлддэг. Бэлгийн мөлжлөгийн хохирогчдын бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндэд олон хохирол учирдаг нь бусдын эрхшээл дарамтад, хамгаалалтгүй бэлгийн харьцаа, бусад эрсдэлээс татгалзах боломжгүй байдагтай холбоотой. Албадлагын биеэ үнэлэлтээс үүдэлтэйгээр хохирогчид БЗДХ төдийгүй ХДХВ-ын халдвар авах эрсдэл өндөртэйг дэлхий нийтээр биеэ үнэлж буй хүмүүсийн ХДХВ-ын халдвар авах магадлал бусад насанд хүрэгчидтэй харьцуулахад ойролцоогоор найм дахин илүү байдаг<sup>51</sup> гэсэн мэдээллээс тодорхой харж болно. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хүсээгүй жирэмслэлт, олон удаагийн үр хөндөлт, эмнэлгийн бус нөхцөл дэх үр хөндөлт, зулбалт зэргээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн асар том эрсдэлд байгаагаа илэрхийлж байна.

### ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар ЭМЯ хохирогчид эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ<sup>52</sup> үйлчилгээ үзүүлэх журмыг батлан хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих, хохирогчид үйлчилгээ үзүүлэх асуудлаар эмнэлгийн байгууллагын ажилтанд сургалт явуулах

<sup>51</sup> ХДХВ ба хуулийн асуудлаарх дэлхийн комисс Эрсдэл, Хүний Эрх, Эрүүл Мэнд, 2012, ХДХВ Ба Хуулийн асуудлаарх Дэлхийн комиссын нарийн бичгийн дарга нарын газар, НҮБХХ, ХДХВ/ДОХ-ын асуудлаарх бүлэг, Хөгжлийн бодлогын товчоо, <https://hivlawcommission.org/wp-content/uploads/2017/06/FinalReport-RisksRightsHealth-Mon.pdf>.

<sup>52</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх (ХХТХ-ийн 12.1.1) журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлан гаргах үүрэг хүлээсэн. Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагаар гэрч, хохирогчоор тогтоогдсон хүн энэхүү журмын үйлчлэлд хамаарна. Тус 2014 оны хамтарсан А/356, А/182 дугаартай журам нь гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон, хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулсан. Энэ журамд 2017 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа мөн адил нэмэлт өөрчлөлт оруулсан.

үүрэг хүлээсэн. Энэ журамд<sup>53</sup> эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв, аймаг дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төвүүд болон СЭМҮТ эмийн болон сэтгэлзүйн зөвлөгөө, заслын эмчилгээг хэрхэн үзүүлэх талаар нарийвчлан зааж өгсөн байдаг. Гэвч энэ журам нээлттэй биш (хуулийн мэдээллийн [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn), салбарын [www.moh.gov.mn](http://www.moh.gov.mn) хуудаст байршаагүй), хэрэгжилт хангалтгүй байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон, хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журмыг 2014 онд ХЗЯ-тай хамтран баталж, 2017 онд өөрчлөн шинэчилсэн ч<sup>54</sup> энэ журамд сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээ багтаагүй. Мөн зөвхөн хамгаалалтад авсан гэрч, хохирогчид үзүүлэх үйлчилгээгээр хязгаарлагдсан тул бусад хохирогчид эрүүл мэнд, сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжгүй байна.

Журамд “эрх бүхий байгууллага” гэдэгт бүх шатны эрүүл мэндийн байгууллага өмчийн хэлбэрээс үл хамааран гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхийг тодорхой заасан. Хамтарсан журмын хүрээнд эрх бүхий байгууллагын хүлээх үүрэгт:

- Гэрч, хохирогчийг эрүүл мэндийн байгууллагад хэвтүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тохиолдолд тэдний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг зөв тогтоож, түүнд тохирсон арга хэмжээ авах;

- Гэрч, хохирогч нь цаг хугацааны хувьд эрүүл мэндийн байгууллагын туслалцааг авах боломжгүй тохиолдолд эрүүл мэндийн анхны болон амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хамгийн ойр орших эрүүл мэндийн байгууллагад хүргэх, гэрч, хохирогчийн гэр бүлийн гишүүнд энэ тухай яаралтай мэдэгдэж, уулзах нөхцөл боломжоор хангах;

- Өөрийн байгууллагын албан хаагчдад эрүүл мэндийн анхны болон амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх дадал, чадвар олгох сургалтыг эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах үүрэгтэй байна.

Дээрх журамд ХХГХ-ийн хохирогчийг эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах талаарх мэдээлэл байсангүй. Харин ЭЦА нь ХХГХ-ийн хохирогчдыг мэргэжлийн ТББ-д хандуулан эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх үйлчилгээнд хамруулдаг байна.

<sup>53</sup> Эрүүл мэндийн сайдын 2013.12.09-нд баталсан “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх тухай” журам, дугаар 462.

<sup>54</sup> Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам, <https://www.legalinfo.mn/annex/details/6562?lawid=10733>.

---

### **Шигтгээ 13.**

*Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдын хувьд бүгд эрүүл мэндийн асуудалтай байдаг. Талита-Ази, Хүйсийн тэгш эрх төв рүү холбон үйлчилгээнд нь хамруулдаг. Тухайлбал, бэлгийн замаар дамжих халдварт өвчтэй, толгой байнга өвддөг, бэртэл гэмтэл авсан байх зэрэг нь түгээмэл байдаг. Үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг байгууллага байдаг эсэх талаар мэддэггүй.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2017 оны журмаар гэрч, хохирогчид эрүүл мэндийн тусламжаа үзүүлэхдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнээс бусад зардлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21<sup>3</sup> дугаар зүйлийн 21<sup>3</sup>.10 дахь хэсэгт заасны дагуу Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас гаргуулж, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх зохицуулалттай.

2019 онд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Тус хуулийн хүрээнд байх “Тусгай сан” нь 24 төрөлтэй байх ба нэг нь гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан юм. Тус сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зориулалттай. Энэ сангаас Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг, 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах, 15.3 дугаар зүйл. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах гэх гэмт хэргүүдийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нөхөн олгохоор заасан<sup>55</sup> ч нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдохоор<sup>56</sup> заасан. Гэвч энэ нь нотлох баримт хангалтгүй, цуглуулах боломжгүй байсан тохиолдолд хохирогчид учирсан хохирол хэдий өндөр ч нөхөн төлөгдөхгүй байх үр дагаварт хүргэж байна.

### **ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

ТББ-ууд нь хохирогчийг яаралтай тусламж, үзлэг, шинжилгээ, эмчилгээнд хамруулахын тулд төлбөртэйгөөр эмнэлгийн үйлчилгээнд хамруулдаг. Үйлчилгээ үзүүлж буй ТББ-ын эрүүл мэндийн тусламж нь анхан шатны үзлэг, шинжилгээ, эмчилгээнд зориулагдсан байдаг тул урт хугацааны эмчилгээ шаардлагатай тохиолдолд үйлчилгээ үзүүлэх боломж хязгаарлагдмал байна. Үйлчлүүлэгчдийн

<sup>55</sup> Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, 10.3 дугаар зүйлд зааснаар 21 төрлийн гэмт хэргийн хохирогчид тусгай сангаас нөхөн төлбөр олгохоор зохицуулсан. <https://www.legalinfo.mn/law/details/14848?lawid=14848>.

<sup>56</sup> Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журам, <https://www.legalinfo.mn/law/details/15913>.

дийлэнх нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй байдаг тул улсын эмнэлгээр үйлчлүүлэхэд хүндрэлтэй, мөн нууцлал алдагдах зэрэг бэрхшээл тулгардаг.

---

#### **Шигтгээ 14.**

*Хүйсийн тэгш эрх төв ТББ нь ХНХЯ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2019-2020 онд нийт 41 үйлчлүүлэгч/хохилогчдыг эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ, тусламжид хамруулжээ.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

#### **4.3.2. Эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ, туслалцаа**

Эргэн нийгэмшүүлэх туслалцааны гол зорилго нь хохирогчийг хувь хүний хувьд хүндэтгэн, хэвийн амьдралдаа эргэн орох, бие даан амьдрах боломж, чадварыг бий болгоход туслах юм. ХХГХ-ийн хохирогчийг эргэн нийгэмшүүлэх туслалцааны төрөл нь эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, санхүүгийн дэмжлэг, хууль зүйн туслалцаа үзүүлэх, боловсрол эзэмших үйл явцыг үргэлжлүүлэх, мэргэжил олгох сургалт, жижиг бизнес эхлүүлэх, орлоготой болоход дэмжих, ажилд зуучлах, амьдрах гэр, байраар хангах зэрэг цогц үйл ажиллагааг үе шаттай үзүүлснээр бодит үр дүнгээ үзүүлдэг. Эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ нь санхүүжилтээс шууд хамааралтай төдийгүй урт хугацааны тогтвортой дэмжлэгийн үр дүнд амжилттай хэрэгжих боломжтой. Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид эргэн нийгэмшүүлэх туслалцаа, үйлчилгээг цогцоор харж тодорхойлсон зохицуулалт байхгүй бөгөөд зарим үйл ажиллагааны чиглэлийг тодорхой яамд журмаар шийдвэрлэхээр зохицуулсан тул хэдийгээр журмууд батлагдсан ч хоорондын уялдаа холбоогүй, салангид, хэрэгжиж буй эсэхэд үнэлгээ өгөх боломжгүй байдал үүсгэж байна.

Хохирогчийг эргэн нийгэмшүүлэх үйлчилгээг ихэнхдээ ТББ-ууд олон улсын донор байгууллагуудын дэмжлэгээр голлон гүйцэтгэж байгаа ч төслийн хугацаа, санхүүжилтийн хэмжээ, хохирогч төвтэй бус хандлагаас шалтгаалан хохирогчийг хэвийн амьдралдаа ортол урт хугацааны туслалцаа, үйлчилгээ үзүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Жил ирэх тутам ХХГХ-ийн хохирогчийн тоо буурахгүй, насанд хүрээгүй хүүхдүүд хохирогч болох нь нэмэгдэж байгаа боловч тэдэнд үйлчилгээ үзүүлэх ТББ-ын тоо нэмэгдэхгүй байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллээр 2020 оны эцэст 25,388 төрийн бус байгууллага бүртгэгдсэн байгаа нь 1998 оноос 23.6 дахин нэмэгдсэн<sup>57</sup> ч үйлчилгээний чиглэлээр ажилладаг ТББ-ын тоо нэмэгдээгүй байгаад анхаарал хандуулах шаардлагатай. Хохирогчид үзүүлэх үйлчилгээнд сүүлийн гурван жил төрөөс жилд 30 орчим сая төгрөгийн дэмжлэг үзүүлж байгаа нь хохирогч хамгаалал, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө

---

<sup>57</sup> Дам эшлэв. ХЗДХЯ, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2021 он.

хүлээсэн үүргээ биелүүлэхэд ахиц гарч буйг илтгэнэ. Гэвч төрөөс хохирогчид үзүүлэх үйлчилгээний санхүүжилтийг бусад бизнесийн, худалдан авалтын тендерүүдтэй адилтгаж зарладаг, зарлагдаж буй санхүүжилтэд ажилтны цалин, хамгаалах байрны татвар, урсгал зардал багтдаггүй тул байгууллага тогтвортой ажиллаж, үйлчилгээ үзүүлж чадахгүйгээс энэ чиглэлийн ТББ-ын тоо нэмэгдэхгүй хэвээр байна. Эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр хохирогч хэвийн амьдралдаа эргэн орж, дахин хохирогч болох, гэмт хэргийн холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байдаг.

#### **4.3.2.1. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт**

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийг мэргэжлийн сургалтад хамруулах, ажлын байраар хангах, үйлчилгээ үзүүлэх журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, хохирогчийг хамгаалах, халамж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих, туслалцаа үзүүлэх<sup>58</sup> үүргийг ХНХЯ-д хүлээлгэсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”<sup>59</sup>-ыг 2015 онд Хөдөлмөрийн яам баталсан боловч энэ журмын дагуу сургалтад хамрагдаж, ажилд зуучлагдсан хохирогч байхгүй байна. Харин 2019 оноос эхлэн ХНХЯ-с БНСУ-ын Засгийн газрын дэмжлэгээр хохирогчдод туслалцаа үзүүлэх, эргэн нийгэмшүүлэх цогц үйлчилгээ үзүүлэх ажлыг ТББ-уудтай хамтран амжилттай хэрэгжүүлж байна. Цаашид төрөөс хохирогчийн мэдээллийн нууцлалыг ханган, мэргэжлийн чиг баримжаа олгох урт, богино хугацааны сургалтад хамруулах, дадлагажуулах, тогтвортой ажлын байраар хангах, төрөөс зорилтот бүлэгт зориулан хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах зэрэг ажлыг цогцоор хийж гүйцэтгэх шаардлагатай. Мөн хохирогчид үзүүлэх үйлчилгээний стандартыг дагаж мөрдүүлэх, үйлчилгээг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тогтмол санхүүгийн эх үүсвэрийг төсөвт хуваарилан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах нь хохирогчид цогц үйлчилгээ үзүүлж, эргэн нийгэмшүүлэхэд чухал үр нөлөөтэй юм.

### **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА**

Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн ур чадвар олгох, сургалтад хамруулах ХНХЯ-ны сайдын журмаар өнөөгийн байдлаар үйлчлүүлэгч/хохирогчийг илгээсэн, хамруулсан мэдээлэл байхгүй байна.

<sup>58</sup> Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, <https://www.legalinfo.mn/law/details/554?lawid=554>.

<sup>59</sup> Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам, (Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаалын хавсралт) <https://www.legalinfo.mn/annex/details/6901?lawid=11340>.

**Хүснэгт 6.** Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн ур чадвар олгох, сургалтад хамруулах журмын товч танилцуулга

Үйлчилгээний төрөл	Үйлчилгээнд хамрагдах үндэслэл	Хэрэгжүүлэгч болон үүрэг хүлээсэн байгууллага	Санхүүжилт
Ажлын байраар хангах  Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулах	Хохирогч нь ажлын байраар хангах, мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамрагдах хүсэлтээ Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлд гаргана.	Дэд зөвлөл нь хохирогчийн хүсэлтийг судалж үзсэний үндсэн дээр албан тоот, мэдээллийг ХНХЯ-ны харьяа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төвд хүргүүлнэ. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төв нь Дэд зөвлөлийн хүсэлтийг хүлээн авч -Ажлын байраар хангах үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн хүрээнд -Мэргэжлийн ур чадвар олгох сургалтад хамруулах үйлчилгээг Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулна.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Ажилд зуучлах үйлчилгээнд хуваарилсан хөрөнгө Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, ажлын байр хадгалах, хөтөлбөрийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэл дээрх сургалтын арга хэмжээнд суурилсан хөрөнгө

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран БНСУ-ын Засгийн газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монгол Улс дахь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчид туслалцаа үзүүлэх” төслийн хүрээнд 2019 онд 10 хохирогч, 2020 онд 10 хохирогчийг мэргэжил олгох сургалтад хамруулжээ.

**Шигтгээ 15.**

*Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Зөвлөл нь Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 онд тав, 2020 онд таван хохирогчийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад суралцуулахад шаардлагатай санхүүгийн дэмжлэгийг Хүйсийн тэгш эрх төв ТББ-аар дамжуулан үзүүлсэн.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

Төслийн хүрээнд үйлчлүүлэгч/хохилогчийг мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын зардал нь 500,000 (таван зуун мянган) төгрөгөөс эхэлж байна. Үйлчлүүлэгч/хохилогчийн сонгосон мэргэжил, тухайн сургалтын төвийн төлбөрийн хэмжээ, үргэлжлэх хугацаа, мэргэшүүлэх байдлаас шалтгаалан сургалтын төвүүдийн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байдаг.

## **ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, чадвар, боловсролын түвшинд тулгуурлан мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулж, цаашдаа ажлын байртай болгох боломжийг бүрдүүлэх чиглэлээр ажилладаг. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын үргэлжлэх дундаж хугацаа нэгээс гурван сар байна. Зарим тохиолдолд үйлчлүүлэгчийн боломжит ажлын байран дээр нь тулгуурлан сургалтад хамруулж, чадавхжуулдаг. Энэ нь үйлчлүүлэгчийг тогтвортой ажлын байртай болгоход гол туслалцаа болж байна.

### ***Шигтгээ 16.***

*Хүйсийн тэгш эрх төв ТББ нь 2006 оноос эхлэн богино хугацааны мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад жилд дунджаар тогтмол 10 үйлчлүүлэгч/хохилогчийг үсчин, гоо сайханч, тогооч, маникюрчин, хүний нөөц-бичиг хэргийн туслах ажилтан, нярав, оёдолчин зэрэг мэргэжлээр суралцуулжээ.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

Төрийн бус байгууллага нь мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг сургалтын төв, бусад төрийн болон ТББ-уудтай хамтран хэрэгжүүлж, үйлчлүүлэгчээ ажлын байртай болоход тусалдаг.

Мөн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд нь үйлчлүүлэгчдийг бие даан амьдрахад бэлтгэх зорилгоор төрөл бүрийн амьдрах ухааны сургалтыг зохион байгуулж байна. Сургалтын үргэлжлэх дундаж хугацаа нэг сар байна. Энэ үйл ажиллагаа нь насанд хүрээгүй хохирогчийг мэргэжлийн чиг баримжаатай болгоход илүү үр дүн үзүүлж байна.

### ***Шигтгээ 17.***

*ЭКПАТ Монгол ТББ нь насанд хүрээгүй хохирогчдод зориулсан амьдрах ухааны төрөл бүрийн сургалтыг зохион байгуулдаг. Нэг удаагийн сургалт нь дунджаар нэг сар үргэлжилдэг. Энэ үйл ажиллагаа нь хүүхдүүдийг мэргэжлийн чиг баримжаатай болгох, мэргэжил сонголтоо хийхэд нь тусалдаг.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*



Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт-үйлчилгээний явцад дараах хүндрэл, бэрхшээл тулгардаг. Үүнд,

- Үйлчлүүлэгчийг урт хугацааны боловсрол олгох хөтөлбөрт хамруулахад шаардлагатай ч төсөв байхгүй учир ТББ-ууд бие даан хариуцах боломжгүй.
- Ажлын байр хангалттай биш, ажилд авах шалгуур өндөр, цалингийн хэмжээ бага гэх зэргээс хүндрэл, бэрхшээл учирч байгаа нь тулгамдсан асуудалд анхаарлаа хандуулж, шийдвэрлэх гарцуудыг цогцоор тодорхойлох хэрэгцээ бий болсныг харуулж байна.

#### **4.3.2.2. Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ**

Урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээний гол зорилго нь хохирогчийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээнд хамруулж тухай үйлчлүүлэгчийг ажил орлоготой болгох замаар бие даан амьдрах боломжийг нь бүрдүүлэхэд туслах юм. ХХГХ-ийн хохирогч эргэн нийгэмшүүлэх хөтөлбөрийг амжилттай дуусган хэвийн амьдралдаа ороход туслах үйл явцыг нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулан авч үзэж байна. Зарим хохирогч гэр бүлдээ эргэж очихыг хүсэхгүй, очих боломжгүй, өөрийн гэсэн орон гэргүй тохиолдолд тэднийг амьдрах гэр, байраар хангах, ажлын байранд зуучлан орлоготой болоход нь туслалцаа үзүүлэн, хэвийн амьдралдаа эргэн орох явцыг түргэтгэх нь урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээний гол цөм нь юм. Гэвч хууль тогтоомжид төрийн дэмжлэгээр хохирогчийг урт хугацаанд нөхөн сэргээх асуудал тусгагдаагүй байна.

### **ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА**

Одоогоор ХХГХ-ийн хохирогчдод урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, эргэн хэвийн амьдралдаа ороход зайлшгүй шаардлагатай амьдрах орон байр, тогтвортой орлоготой болох ажлын байраар хангах, насанд хүрээгүй хохирогчдын суурь боловсролыг эзэмшүүлэх талаарх үйлчилгээг зохицуулсан хууль тогтоомж, стандарт байхгүй.

### **ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА**

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд үйлчлүүлэгчийг амьдрах орон байр, тогтвортой ажлын байртай болгох нь хүндрэлтэй асуудлын нэг хэвээр байна. Тэд ажлын байртай болсон ч цалин бага, үйлчилгээний байгууллагуудын тогтвортой байдал хангагдаагүй хэвээр буй тул амьжиргааны наад захын хэрэгцээг нь хангахгүй байна. Нөгөө талаас ажлын туршлага багатайгаас шалтгаалж хүссэн ажлын байр нь олддоггүй. Мөн ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан тогтмол ажил эрхлэх боломж хязгаарлагдмал байдаг тул гэр бүлийг орлоготой болоход дэмжлэг үзүүлэх, гэр бүлийн гишүүдийг эрхэлж буй жижиг үйлдвэрлэл, үйлчилгээнд хамтад нь хамруулах талаар бодлого барьж ажиллах нь эргэн нийгэмшүүлэхэд илүү үр дүнтэй болох нь Хүйсийн тэгш эрх төвийн мэдээллээс харагдаж байна. Тус төвөөс ШХА, Канад сангийн дэмжлэгээр

гурван жил дараалан тус бүр 10 хохирогчийн гэр бүлд эхлэлийн бизнес хийхэд нь шаардлагатай сургалтыг энэ чиглэлээр мэргэшсэн ТББ-ын тусламжтайгаар явуулж, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн дэмжлэг үзүүлснээр эдгээр үйлчлүүлэгчийн гэр бүлийн бизнес өргөжсөн байна. Гэвч энэ нь нэг удаагийн богино хугацааны төслийн хүрээнд хэрэгжсэн тул цаашид олон хүнд тогтвортойгоор хүргэх боломжгүй болжээ.

Маш цөөн тохиолдолд зайлшгүй хэрэгцээ бий болсон хохирогчдод зарим хөтөлбөр, төслийн хүрээнд амьдрах орон байртай болох боломж олддог. Гэвч үйлчлүүлэгч өөрийн өмчилж авсан газаргүйгээс түрээсийн хашаа дамжиж олон удаа нүүх, эсвэл өмчилж авсан газар нь дэд бүтэцгүй, хэт алслагдсан байх, нөгөө талаас ганц бие, нялх, бага насны хүүхдүүдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд бие даан гэрт амьдрах нь хүндрэлтэй байх нь бий. Иймээс энэ нь ТББ-уудын хувьд хамгийн хүндрэлтэй ч зайлшгүй шаардлагатай үйлчилгээний нэг нь хэвээр байна. Тиймээс зарим ТББ-ууд энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор өөр боломжит үйлчилгээг судлан туршиж эхэлжээ. Тухайлбал, Талита Ази ТББ нь бие даан амьдрахад өөрийгөө бэлтгэх (12-24 сар), ажил хөдөлмөр эрхлэх, болон бие даан амьдрах, нийгмийн харилцаанд оролцоход бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Хохирогчийг нөхөн сэргээх үйлчилгээний журмыг боловсруулан түүнд үйлчилгээний үргэлжлэх хугацаа, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлт, анхан шатны болон удаан хугацаанд нөхөн сэргээхэд зайлшгүй шаардлагатай хэрэгцээг хангахын тулд төрийн бусад үйлчилгээтэй хэрхэн уялдуулах талаар нарийвчлан зааж, хэрэгжилтийн үр дүнд хяналт тавьж ажиллавал илүү үр дүнтэй.

---

### ***Шигтгээ 18.***

*Хүйсийн тэгш эрхийн төв нь үйлчлүүлэгч, түүний гэр бүлийн гишүүдийн дунд жижиг бизнес эрхлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Тэднийг жижиг бизнес эрхлэх чиглэлээр сургах, чадавхжуулах замаар бие даан орлого олох, ажлын байртай болгох аргачлалыг туршиж байгаа юм. Тухайлбал 2020 онд дөрвөн үйлчлүүлэгчийг “Бизнес эхлэл (start-up)” үйлчилгээнд хамруулсан.*

*Ганцаарчилсан ярилцлагын хэсгээс*

---

## ТАВДУГААР БҮЛЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭЖ БҮЙ БУСАД УЛС ОРНЫ ТУРШЛАГА

Дэлхий нийтээр хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх ба түүнтэй тэмцэх, хүн худалдаалах хэргийн хохирогчдыг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх чиглэлээр олон сайн туршлага бий болсон. Хүний эрхийг дээдэлж, өөрсдийн орны хууль тогтоомжийг сайжруулан, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалах, гэмт хэрэгтнийг шударгаар шийтгэх, гэмт хэргийг таслан зогсооход улс орнуудын хамтын ажиллагаа нэмэгдэж байна. ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагааг “4P” хэмээх загвараар тодорхойлон, олон улсын хэмжээний тайлан, илтгэлүүд гарч, энэ чиглэлээр туршлага солилцох боломжийг бий болгож байна.

АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр гаргадаг “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан илтгэл”-д БНСУ, АНУ нь тасралтгүйгээр 1 дүгээр шатлалд эрэмбэлэгдэж буй бөгөөд Филиппин улс 2015 оноос эхлэн энэ ангилалд шилжиж орсон байна. Монгол Улс 2006 оноос хойш 2 дугаар ангилалд шатлалд 14 жилийн турш орж байна. 2017 онд шинэчилсэн Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2002 оны Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлээр шалгагдаж байсан 26 хэрэг хэрэгсэхгүй болсон тул 2018 онд энэ шатлалын ажиглалтын буюу анхаарал татаж буй орны жагсаалтад орж байсан.

### 5.1. “4P”-ийн загвар

“4P”-ийн загвар нь хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр олон улс оронд ашигладаг олон улсын тогтолцоо бөгөөд “P”(латин цагаан толгойгоор) тус бүр хүн худалдаалахын эсрэг нэг үйл ажиллагааг илэрхийлдэг. Хүн худалдаалахтай тэмцэх олон улсын хамгийн гол баримт бичиг болох Хүн худалдаалахтай тэмцэх протокол нь анх хүн худалдаалахыг гэмт хэрэгт тооцох, хохирогчдод туслас, сэргээн засах, нийгэмшүүлэх хөтөлбөрүүдийг бий болгоход чиглэсэн “3P”-ийн (prevention/урьдчилан сэргийлэх, prosecution/ял шийтгэл оногдуулах, protection/хохирогч хамгаалал) загварыг гаргасан<sup>60</sup>. Дөрөв дэх “P буюу partnership/хамтын ажиллагааг улс орон дотроо төдийгүй олон улсын оролцогч талуудын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр “3P” дээр нэмж оруулсан<sup>61</sup>.

“3P” нь тусдаа салангид биш харин хоорондоо салшгүй, уялдаа холбоо бүхий ойлголт юм. “P” тус бүр зайлшгүй шаардлагатай бөгөөд харилцан бие биеэ баталгаажуулж байдаг. Дөрөв дэх “P” буюу хамтын ажиллагаа нь “3P”-

<sup>60</sup> Хила Шамир., “Хүн худалдаалах хэргийн хөдөлмөрийн парадигм”, Калифорнийн их сургууль, Лос Анжелес, Хуулийн тойм-76 (2012 он), <https://www.uclalawreview.org/pdf/60-1-2.pdf>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

<sup>61</sup> Доктор Мария Йованович, “Хүн худалдаалахтай тэмцэх хууль эрх зүйн дэглэм ба Европын Зөвлөл ба АСЕАН-ны харьцуулалт: Бодит байдал, хүрээ, хамтын ажиллагааны боломжууд”, 2018 оны 5 сар, [https://rm.coe.int/coe-asean-study-thb/16808c1b918\\_](https://rm.coe.int/coe-asean-study-thb/16808c1b918_), (сүүлд үзсэн: 2021.09.20).

ийн түвшинд ахиц дэвшил гаргаж, хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд нийгмийн бүх хэсгийг хамруулах нэмэлт хэрэгсэл болдог.

### **5.1.1. Урьдчилан сэргийлэх/Prevention**

Урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй болгоход хүн худалдаалагчдын арга тактикийг судлах, задлан шинжлэх нь хамгийн чухал ач холбогдолтой. Тэдгээр арга тактикийн талаарх судалгаанд суурилсан, нарийн тодорхой мэдээллийг түгээснээр олон нийт хүн худалдаалагчдын завдалт, заналхийлэлд тохирсон, зөв хариу арга хэмжээ авах бэлтгэлтэй болно. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд Филиппин улсын мэдээлэл өгөх шууд утас, хилийн чанадад байгаа иргэдэд зориулсан шуурхай утас, БНСУ-ын жилд 10,000 сайн дурын ажилтныг үйл ажиллагаандаа татан оролцуулж, урьдчилан сэргийлэх сурталчилгаа зохион байгуулдаг аргачлал, АНУ-ын хамтарсан форумаас сурталчилгааны материал агуулга, загварыг харилцан тохиролцож гаргаж түгээдэг, мөн Засгийн газраас төрийн, ТББ-ын ажилтнуудад сургалт зохион байгуулдаг БНХАУ-ын сураггүй алга болсон хүүхдүүдийг олох, аврах ажилд суурилсан системийг амжилттай хэрэгжүүлж буй зэрэг туршлагауудыг онцолж байна. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх зорилгоор БНСУ-д ерөнхийлөгчийн зарлигаар биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийг таслан зогсоох долоо хоногийг зарлаж, улс даяар олон нийтэд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээдэг бол АНУ-д жил бүрийн нэгдүгээр сарыг ХХГХ-тэй тэмцэх сар болгон улс даяараа ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх олон төрөл, хэлбэрийн үйл ажиллагааг зохион байгуулдаг. Мөн улс орон бүр өөрийн орны онцлогт тохирсон сургалт, сурталчилгааны хөтөлбөртэй, тэдгээрийн хэрэгжүүлэх арга замыг Үндэсний хөтөлбөрүүдэд маш тодорхой тусгасан нь үр дүн гарахад чухал нөлөөтэй байна.

### **5.1.2. Хохирогч хамгаалал/Protection**

Олон улсын хэмжээнд хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хохирогч төвтэй хандлагын гол үндэс нь хохирогч хамгаалал болдог. Хохирогчийг үр дүнтэйгээр хамгаалах ажилд тэднийг идэвхтэй таньж тогтоох, илрүүлэх, сэтгэцийн гэмтэл, шархны талаар харгалзан үздэг арга барил бүхий мэдээлэлтэй цогц үйлчилгээнд холбон зуучлах, тэдгээр үйлчилгээг үзүүлэгч ТББ-уудад шууд тусламж, санхүүжилт олгох, хохирогчдын энгийн амьдралдаа эргэн ороход дэмжлэг үзүүлэх зэрэг хамаарна. Судалгаанд хамрагдсан улсуудад ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах хуулийг баталж, хохирогчид үзүүлэх цогц үйлчилгээг төрөөс тогтвортой санхүүжүүлж байгаа нь манай улсад жишиг болохуйц үйл ажиллагаа гэж үзлээ. 2020 онд Филиппин улс ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаанд 1,83 сая ам.доллар, ХХГХ-ийн хохирогчдыг нөхөн сэргээх үйлчилгээнд 480,000 ам.доллар, АНУ ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаанд 101 сая ам.доллар<sup>62</sup>, 73 хамгаалах байранд 35 сая ам.доллар, БНХАУ 2016 онд 55 сая

<sup>62</sup> <https://www.justice.gov/opa/pr/justice-department-awards-nearly-101-million-combat-human-trafficking>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

юань төсөвлөж зарцуулжээ. АНУ хохирогч төвтэй хандлагыг удирдлага болгож, сэтгэл зүйн гэмтлийг онцгойлон авч үздэг бол БНСУ удаан хугацааны буюу 36 сар хүртэлх нөхөн сэргээх үйлчилгээг үе шаттай хэрэгжүүлдэг байна. Филиппин улс нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үндэсний мэдээллийн сангаар дамжуулан үйлчилгээнд хяналт тавьж, иж бүрэн, цогц үйлчилгээнд хамруулдаг юм. Энэ бүх ажиллагааг төрийн нийгмийн халамжийн байгууллагууд болон ТББ-ууд хамтран үзүүлдэг. АНУ-ын Засгийн газраас гадаад улсын харьяат хохирогчдод зориулсан T, U ангиллын<sup>63</sup> визний зохицуулалттай бөгөөд гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хамгаалалтад авч, шаардлагатай бүх талын туслалцааг үзүүлдэг. БНСУ “Бэлгийн мөлжлөгийн хохирогчийг таньж тогтоох удирдамж” (GIST- Guidelines for Identification of Sex-Trafficking victim)-ийг боловруулж, Биеэ үнэлэх, түүнд зуучлах үйлдлийг шийтгэх тухай хуулийг хэрхэн хэрэглэж, ял шийтгэл оногдуулах, хохирогчийг хамгаалалтад авах, хохирлыг барагдуулах, туслалцаа үзүүлэх талаар хуулийн зохицуулалт тус бүрийг бодит тохиолдолд тулгуурлан, хэрхэн хэрэглэх заавар, удирдамжийг боловсруулан хэрэглэж байна.

### **5.1.3. Ял шийтгэл оногдуулах/Prosecution**

Хууль сахиулах байгууллагаас хохирогчийг таньж тогтоох, хүн худалдаалагчдын үйлдлийг таслан зогсоох чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ авах нь засгийн газрын хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны салшгүй хэсэг юм. Туршлага судалсан дөрвөн улсын хувьд хүн худалдаалах гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулахдаа “хүчиндэх” гэх мэт бусад хүнд гэмт хэргүүдийн адил ноцтойгоор авч үзэж 20 хүртэлх жил болон бүх насаар нь хорих ял оноох, их хэмжээгээр торгох ял шийтгэл оногдуулж байна. АНУ, Филиппин улс хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид засгийн газраас нөхөн олговор олгодог байна. Филиппин улсад уг нөхөн олговор дээр нэмэгдэн хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч хохирогчид төлөх нөхөн төлбөр олгохоор хуульчилсан. БНСУ нөхөн төлбөр авахын тулд иргэний хэрэгт гомдол гаргах зохицуулалттай. Тус улс насанд хүрээгүй хохирогчийг биеэр оролцуулахгүйгээр видео болон бусад цахим аргаар гэрчийн мэдүүлэг авах, эцэг эх, асран хамгаалагчтайгаа мэдүүлэг өгөхийг зөвшөөрдөг бол Филиппин улс хохирогчийн аюулгүй байдлыг хангаж, эрсдэлгүй болсны дараа мэдүүлэг авах, хүүхдийг дахин сэтгэцийн гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор харилцан тохиролцож гэм бурууг хүлээлгэх аргыг шүүхийн шатанд ашигладаг.

### **5.1.4. Хамтын ажиллагаа/Partnership**

Хүн худалдаалахтай тэмцэхэд олон төрлийн хувь хүн, байгууллагын мэдлэг туршлага, нөөц, хүчин чармайлт шаардлагатай. Хамтын ажиллагаа нь олон салбарын туршлагыг нэгтгэх, ижил санаа бодол, зорилгоор гэмт хэрэгтэй тэмцэх, нөөцийг ашиглах замаар хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлж, улмаар

<sup>63</sup> <https://immsolutionsllc.com/immigration/visas-victims-crimes-abuse/t-visa><https://immsolutionsllc.com/immigration/visas-victims-crimes-abuse/t-visa>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

аль ч байгууллага, салбар дан ганцаар хүрч чадахгүй үр дүнд хүрэх, үр нөлөөтэй ажиллах боломж олгодог.

Филиппин улсын Хүн худалдаалахтай тэмцэх байгууллага дундын зөвлөл нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зорилго, зорилтод хүрэхэд шаардлагатай бүх эрх мэдлийг хэрэгжүүлж, бусад хамаарах бусад чиг үүргийг гүйцэтгэдэг. Удирдлага нь Хууль зүйн газарт, хамтарсан удирдлага нь Нийгмийн халамж, хөгжлийн газарт байдаг бөгөөд засгийн газрын бусад байгууллагууд, ТББ-ын төлөөлөл багтаж, орон нутгуудад 24 ажлын хэсгийг уялдуулан зохицуулж ажилладаг. Засгийн газраас энэхүү зөвлөлд жил бүр ХХГХ-тэй тэмцэх, хохирогчдод туслалцаа үзүүлэхэд шаардлагатай төсвийг хуваарилдаг.

БНСУ-д Гадаад хэргийн сайдаар удирдуулсан бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн эсрэг үйл ажиллагааг зохицуулах байгууллагууд дундын ажлын алба 2020 оны гуравдугаар сард байгуулагдсан. Энэ албанд Ерөнхийлөгчийн гүйцэтгэх алба болон зургаан яамны дээд түвшний төлөөлөгчид багтдаг. Мөн тухайн алба НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын тухай 1325 тоот тогтоолын хэрэгжүүлэх БНСУ-ын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлдэг.

БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам нь хүн худалдаалахтай тэмцэх байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулж, Нийгмийн аюулгүй байдлын цогц удирдлагын төв газар, Хууль зүйн яам зэрэг засгийн газрын төв салбар нэгж, агентлагууд бүрэлдэхүүнд нь багтдаг байна. Хамтарсан зөвлөгөөний ажлын алба нь Олон нийтийн аюулгүй байдлын яамны Эрүүгийн хэрэг мөрдөн байцаах газар байрладаг бөгөөд тус газрын Ерөнхий захирал нь албыг хариуцаж ажилладаг. БНХАУ нь Хүн худалдаалахтай тэмцэх Меконгийн<sup>64</sup> сайд нарын хамтарсан санаачилга (COMMIT санаачилга)<sup>65</sup>-д 2004 оноос нэгдэн хамтран ажиллаж байна. НҮБ-ын Хүн худалдаалахтай тэмцэх хамтын ажиллагааны үйл ажиллагаа (UN-ACT: United Nations Action for Cooperation Against Trafficking in Persons) нь COMMIT санаачилгын нарийн бичгийн дарга нарын газрын үүргийг гүйцэтгэж, Дээд Меконг бүс болон түүнээс цааш бүс нутагт хүн худалдаалахтай тэмцэх ажлыг илүү стратегитай, үр дүнтэй зохион байгуулахыг баталгаажуулж ажилладаг<sup>66</sup>.

АНУ-ын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хянах Ерөнхийлөгчийн дэргэдэх ажлын алба (PITF) нь 2000 оны хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хуулийн дагуу байгуулагдсан Засгийн газрын түвшний байгууллага бөгөөд АНУ-ын Засгийн газрын үйл ажиллагааг

<sup>64</sup> Гишүүн орнууд: Камбож, Лаос, Мьянмар, Тайланд, Вьетнам

<sup>65</sup> Хүн худалдаалахтай тэмцэх Меконгийн сайд нарын хамтарсан санаачилга (COMMIT санаачилга), ОУШХБ <https://www.iom.int/coordinated-mekong-ministerial-initiative-against-trafficking-commit-process>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

<sup>66</sup> НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүн худалдаалахтай тэмцэх хамтын ажиллагааны үйл ажиллагаа (UN-ACT) 2014-2018, <http://kidnap.bz.cn/html/aboutEnglish/>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

зохицуулах үүрэг бүхий 20 агентлагаас бүрддэг. Энэхүү ажлын албыг Төрийн нарийн бичгийн дарга удирддаг<sup>67</sup>. Байгууллага дундын зохицуулах Ерөнхий бодлогын үйл ажиллагааны бүлэг нь 2003 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Төрийн департаментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих албаар ахлуулдаг<sup>68</sup>.

“4P” буюу урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, ял шийтгэл оногдуулах, хамтын ажиллагааны хүрээнд бусад улсуудын хүрсэн амжилт, үр дүнтэй үйл ажиллагаа, төлөвлөлтөөс бид өөрийн улсын ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаанд авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн хэсгүүдээс түүвэрлэн танилцуулж байна. Энэ талаар дэлгэрүүлэн уншиж, судлахыг хүсвэл хавсралтад байгаа эх сурвалжуудын холбоосоор авч уншина уу.

## 5.2 Бусад улс орны туршлага

### 5.2.1. Филиппин Улс

Улсын хэмжээнд хүн худалдаалахтай тэмцэх байгууллага хоорондын зөвлөл (ХХТБХЗ), бүс нутгийн 24 зөвлөл байнгын мэдээлэл солилцож байгууллага хоорондын үйл ажиллагааг уялдуулан ажилладаг. Засгийн газраас 2020 онд ХХТБХЗ-ийн Нарийн бичгийн дарга нарын газарт 1.83 сая ам долларыг хуваарилсан). Тус улсад ХХГХ-тэй тэмцэх, хохирогчдыг хамгаалах чиглэлээр байгууллагууд юу хийхийг маш тодорхой зааж өгсөн байдаг. Үүнд:

Хууль зүйн яам	<p>Хяналт тавьж, зохицуулалт хийж ажилладаг байгууллага хоорондын 24 ажлын хэсэг:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хууль зүйн яамаар ахлуулсан ажлын хэсэг;</li> <li>- Үндэсний агентлагуудын ажлын хэсэг;</li> <li>- Бүсийн 16 ажлын хэсэг;</li> <li>- Агаарын болон далайн боомтын 6 тусгай анги.</li> </ul>
Гадаад харилцааны яам	<ul style="list-style-type: none"> <li>- Бусад улс орнуудтай байгуулсан хөдөлмөрийн хоёр болон олон талт хэлэлцээрүүдээ эргэн шалгаж, иргэдийн эрхийг хамгаалах, ХХГХ-т өртөх магадлалыг бууруулах үйл ажиллагаа;</li> <li>- Хилийн чанадад илэрсэн хохирогчдод зориулсан төсөв (нислэгийн тийз, байр, хоол, эмнэлгийн үйлчилгээ, хууль эрх зүйн туслалцаа)-г Үндэсний иргэдэд тусласан сан, Хууль зүйн туслалцаа үзүүлэх сан, гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаар дамжуулан хуваарилдаг.</li> </ul>

<sup>67</sup> Ерөнхийлөгчийн дэргэдэх ажлын алба, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих алба, 2020 он <https://www.state.gov/the-presidents-interagency-task-force/>.

<sup>68</sup> Засгийн газрын чиглэл, АНУ-ын Хууль зүйн департамент, 2020 он, [72](https://www.justice.gov/humantrafficking/whole-government-approach#:~:text=U.S.%20Department%20of%20Homeland%20Security&text=U.S.%20Immigration%20and%20Customs%20Enforcement%20(ICE)%2C%20the%20largest%20investigative,human%20smuggling%20and%20human%20trafficking, (сүүлд үзсэн: 2021.09.20).</a></p>
</div>
<div data-bbox=)



Хөдөлмөр, ажил эрхлэлтийн газар	Мөрдөн байцаалтын явцад тогтоогдсон ХХГХ-г холбогдсон, үйлдсэн хувийн байгууллагуудыг үйл ажиллагааг зогсоодог.
Филиппиний хилийн чанад дахь хөдөлмөр эрхлэлтийн газар	<ul style="list-style-type: none"> <li>- Холбогдох хууль сахиулах байгууллагуудтай хамтран хүн худалдаалах, элсүүлэхэд холбогдсон хүмүүсийн мэдээллийн санг боловруулсан;</li> <li>- ХХГХ-т элсүүлэх, өртүүлсэн хэргийг шүүхэд өргөдөл гаргаж шалгуулж, шийдвэрлүүлдэг;</li> <li>- Хууль сахиулах байгууллагууд болон бусад албан тушаалтнуудад ХХГХ-ийг хэрхэн илрүүлэх талаар сургалт зохион байгуулж, орон нутагт зохион байгуулах сургагч багш нарыг ТББ-аас бэлтгэдэг.</li> </ul>
Цагаачлалын алба	Гадаадад бүртгэгдсэн бэлгийн хүчирхийлэгчдийг хилээр нэвтрэхийг хориглодог.
Цагаачлалын албаны Аялал жуулчлалыг хянах алба	Хилээр нэвтрэгч буй зорчигчдыг шалгаж, аяллын бичиг баримт нь дутуу, сэжигтэй тохиолдолд хилээр гаргахыг нь хойшлуулж, ХХГХ-тэй тэмцэх ажлын хэсэгт шалгуулахаар шилжүүлдэг.
Хилийн чанад дахь Филиппиний Комисс	ХХГХ-ийн талаар мэдээлэл өгөх 1343 шууд утас ажиллуулж, дуудлага хүлээн авдаг.
Филиппин улсын цагдаагийн газар, Эмэгтэйчүүд, хүүхдийг хамгаалах төв	Хүүхдийг цахим хэлбэрээр бэлгийн мөлжлөгт ашиглаж байгааг мэдээлэх утас, мессежний шугам ажиллуулдаг.
Нийгмийн халамж хөгжлийн газар (НХХГ)	ХХГХ-ийн хохирогчдыг нөхөн сэргээх болон интеграцийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, нөхөн сэргээлт, нийгэмшүүлэх чиглэлээр үндэсний мэдээллийн санг бүрдүүлдэг ба үндэсний лавлагааны системийг хариуцдаг. 2020 оны төсөв нь 480,000 америк доллар.
ТББ-ууд	Орон байрны дэмжлэг, нийгэмшүүлэх үйлчилгээ, нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтын чиглэлээр мэргэшсэн ТББ-тай засгийн газар хамтран ажилладаг. Засгийн газар нь ТББ-ын харьяа хамгаалах байруудад төсөв хуваарилдаг. Эмэгтэйчүүд, хүүхэд, эрэгтэйчүүдэд зориулсан тусдаа байруудтай.
Гэмт хэргийн хохирогчдын нөхөн олговрын хөтөлбөр	Хохирогчдод засгийн газраас нөхөн олговор олгодог. Түүнчлэн ХХГХ-ийн хүн худалдаалах хэргийн гэмт хэрэгтэн, яллагдагч хохирогчдод төлөх нөхөн төлбөр гэж байдаг.

Филиппин улс Гадаад харилцааны яамны дэргэдэх нийгмийн халамжийн атташе гэсэн албан тушаал бий болгожээ. Мөн хууль сахиулах байгууллагууд хууль сахиулах үйл ажиллагааны явцад тогтоосон хохирогчдыг хүн худалдаалах хэргийн нөхцөл байдлаас холдуулж, Нийгмийн халамж, хөгжлийн газартай хамтран хохирогчдыг хамгаалах байранд байрлуулан, эрсдэлгүй болсны дараа нэн даруй ярилцдаг.

ХХГХ-ийн хохирогчдод цогц үйлчилгээ үзүүлдэг бөгөөд эрүүгийн хэргийн шүүх хуралд гэрчээр оролцсон хохирогчдод мэдээлэлд суурилсан сэтгэцийн цогц эмчилгээ, хамгаалах үйлчилгээ үзүүлдэг. Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр томилогдсон прокурорууд сэжигтэй мөнгөн гуйвуулгыг шинжлэн бэлгийн мөлжлөг, хүүхдийн цахим бэлгийн мөлжлөгийг мөрдөн шалгадаг.

Шүүхийн шатанд насанд хүрээгүй хохирогчтой хийсэн ярилцлагын бичлэгийг ашиглах эсвэл харилцан тохиролцож гэм буруугаа хүлээх аргыг хэрэглэдэг ба бичлэгийг ялангуяа хүүхдийг дахин сэтгэцийн гэмтэл авахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг.

Манай улсад холбогдох байгууллагууд хуульд заасан чиг үүргийн дагуу үйл ажиллагаагаа хохирогчийг таньж тогтоох, аврах, туслалцаа үзүүлэх талаар илүү тодорхой болгож, харилцан уялдаатай ажилладаг энэ туршлагыг хэрэгжүүлэх боломжтой.

### 5.2.2. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-д Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах байгууллага дундын албанд Хууль зүйн департамент, Дотоодын аюулгүй байдлын департамент, Холбооны мөрдөх товчоо багтдаг бөгөөд хүн худалдаалах хэргийг мөрдөн байцаах, ял шийтгэл оногдуулах зорилготой<sup>69</sup>.

Тус улсад хүн худалдаалахтай тэмцэх шууд утсыг Эрүүл мэнд, хүний үйлчилгээний департамент санхүүжүүлж, 2007 оноос эхлэн ТББ улс даяар хариуцан ажиллуулдаг<sup>70</sup>.

<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хянах Ерөнхийлөгчийн дэргэдэх ажлын алба (PITF)</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 2000 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хуулийн дагуу байгуулагдсан Засгийн газрын түвшний байгууллага;</li> <li>- АНУ-ын засгийн газрын үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий 20 агентлагуудаас бүрддэг, ажлын албыг Төрийн нарийн бичгийн дарга удирддаг<sup>1</sup>;</li> <li>- Байгууллага дундын зохицуулах Ерөнхий бодлогын үйл ажиллагааны зохицуулах бүлэг нь 2003 оны Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу Төрийн департаментын Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, хяналт тавих албаар ахлуулдаг<sup>2</sup>.</li> </ul>
--	--

<sup>69</sup> Anti-Trafficking Coordination Team Initiative is a multi-agency initiative (DOJ, HS, FBI) with inter-agency teams for investigation and prosecution of human trafficking.

<sup>70</sup> <https://polarisproject.org/>. (сүүлд үзсэн: 2021.09.20).

Холбооны мөрдөх товчоо	<ul style="list-style-type: none"> <li>- ХМТ-ны хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөр нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар мөрдөн байцаалт явуулах;</li> <li>- Хүүхдийн эсрэг цахим гэмт хэрэгтэй тэмцэх ажлын алба нь технологи ашигласан хүүхдийн бэлгийн мөлжлөг, хүүхдийн эсрэг цахим гэмт хэрэгт хариу арга хэмжээ авах;</li> <li>- Холбооны мөрдөх товчооны хохирогчдын үйлчилгээний хэсэг нь сэтгэл зүйн хямралын хариу арга хэмжээ, хэрэгцээний үнэлгээ, хохирогчийн мэдэгдэл, үйлчилгээнд холбон зуучлах.</li> </ul>
Засгийн газар	<ul style="list-style-type: none"> <li>- ХХГХ-ийн хохирогчдыг таних, үйлчилгээ үзүүлэгч байгууллагад холбон зуучлах чиглэлээр албан хаагчдыг удирдан чиглүүлдэг албан ёсны журмыг батлах хэрэгжүүлэх;</li> <li>- ХХГХ-ийг мөрдөн шалгах ажиллагааны мужийн болон орон нутгийн түвшний мэдээллийг Гэмт хэрэг нэгдсэн мэдээлэх хөтөлбөрөөр (ГХМХ) дамжуулан цуглуулах;</li> <li>- Хохирогчдод үзүүлэх цогц тусламжийг санхүүжүүлэх Үүнд: хэргийг шийдвэрлэх, эмнэлгийн, шүдний, сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, мансууруулах бодисын хамаарлаас нөхөн сэргээх, хоол хүнс, хамгаалах байр, орчуулгын үйлчилгээ, цагаачлалын ба хууль эрх зүйн туслалцаа, хөдөлмөр эрхлэлт, сургалт, тээврийн хэрэгслээр туслах үйлчилгээ зэрэгт холбон зуучлах.</li> </ul>
Хууль зүйн департамент	<ul style="list-style-type: none"> <li>- Хүн худалдаалахын эсрэг чадавхыг бэхжүүлэх төв нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод дэмжлэг үзүүлдэг байгууллага, нийгэмлэгүүдийн чадавхыг бэхжүүлдэг;</li> <li>- Гэмт хэргийн хохирогчдын алба нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод 6-24 сарын хугацаанд байраар хангах үйлчилгээ үзүүлдэг 73 байгууллагад 35 сая ам долларыг олгожээ<sup>3</sup>;</li> <li>- Хүн худалдаалах гэмт хэрэг болон бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхэд, залууст үйлчилгээ үзүүлдэг 65 байгууллагад санхүүжилт олгосон.</li> </ul>
Эрүүл мэнд, хүний үйлчилгээний департамент	<ul style="list-style-type: none"> <li>- Гэр бүл, эрсдэлт бүлгийн залууст хүргэдэг хөтөлбөрт нийцсэн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх материал, сургалтыг боловсруулах;</li> <li>- Хүн худалдаалах хэргийг шийдвэрлэдэг, хохирогч хамгаалал, хохирогчоортоогтоогдожхэрэгшийдвэрлүүлэхэд үйлчилгээ үзүүлдэг хүүхдийн халамжийн тогтолцоо, асрамжийн газруудад санхүүжилт олгосон.</li> </ul>

STOP хөтөлбөр (АНУ-ын Цагаачлал, гаалийн алба, Дотоодын аюулгүй байдлын мөрдөн байцаах албаны Стратегийн зорилтот сурталчилгааны хөтөлбөр)	- Гол салбаруудыг оролцуулж, хүн худалдаалах гэмт хэргийг таньж, мэдээлэх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр ажилладаг
--	---

АНУ-ын Тагнуулын төв газрын хүүхдийн хөтөлбөр нь хүүхэд худалдаалах, хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаар мэдээллийг хүүхдүүд болон эцэг эхчүүдэд өгдөг. Олон нийтийн мэдлэг, сурталчилгааны хороог Эрүүл мэндийн, хүний үйлчилгээний, Дотоодын аюулгүй байдлын департаментууд болон Төрийн департаментын хамт удирдаж, байгууллагуудын форум зохион байгуулан төлөвлөгөөт арга хэмжээ, сурталчилгааны материалын талаар мэдээлэл солилцож, давхардуулахаас зайлсхийж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангадаг. Тус хорооноос сурталчилгааны нийтлэг санаа, статистикийн стандартчилсан багц, зургийн удирдамжийг сурталчлах олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх материалын удирдамжийг гаргасан.

Эрх зүйн орчны хувьд Хүн худалдаалах хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хууль (2000) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдын шударга ёсны тухай хууль (2015), Хүн худалдаалах хэргийн хохирогчдод дэмжлэг үзүүлэх тухай хууль 2015, Хүн худалдаалан наймаалахыг таслан зогсоох тухай хууль (2017), Хүн худалдаалах хэргийн хохирогчдыг хамгаалах тухай хууль (2017), Фредрик Дугласын Хүн худалдаалах хэргээс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах тухай хууль (2018) болон бусад холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд оржээ.

Үүнээс харахад ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх, хохирогчийг хамгаалах бүх үйл ажиллагааг тодорхойлон хуульчилж өгснөөр хохирогчийг илрүүлэхээс эхлэн бүх шатанд үзүүлэх үйлчилгээ тодорхой болж, зохицуулалтын хийдэл үүсэхээс урьдчилан сэргийлж чадсан байна. Манай ХХГХ-тэй тэмцэх тухай хуульд байгууллагуудын үүрэг, оролцоог зааж өгсөн ч бусад гэмт хэргээс онцлог, ялгаатай ХХГХ-ийн хохирогчийн эрхийг хамгаалах хуульгүйгээс Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар хамгаалагдах боломж нь хязгаарлагдмал хэвээр байна<sup>71</sup>.

<sup>71</sup> Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд "гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг; "хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ гэж заасан байдаг нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хохирогчийн тодорхойлолттой зөрдөг тул эрүүгийн хэрэг үүсэхээс өмнөх шатанд хохирогч хамгаалалт авах боломжгүй байдаг.

АНУ-ын бүх муж, нутаг дэвсгэрүүд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуультай бөгөөд АНУд үйлдэгдсэн ихэнх гэмт хэргийг мужийн хуулиар хянан шийдвэрлэдэг. АНУ-ын Засгийн газар Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө (2020-2023)-г боловсруулж, хүн худалдаалахтай тэмцэх өргөн хүрээний, олон талт, засгийн газрын бүх түвшинг хамарсан арга ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, чадавхаа сайжруулах, одоо байгаа эрч хүчээ нэмэгдүүлэхэд шаардагдах тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг дөрвөн тулгуур үйл ажиллагааны хүрээнд тодорхойлсон<sup>72</sup>.

**Тулгуур үйл ажиллагаа 1: Урьдчилан сэргийлэх** - Хүн худалдаалахтай тэмцэх бүх үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий нэг ч байгууллага байдаггүй.

**Тулгуур үйл ажиллагаа 2: Хамгаалах** - Хүн худалдаалах хэргийн хохирогчдыг таньж илрүүлэх, туслах, хамгаалах.

**Тулгуур үйл ажиллагаа 3: Яллах** - Хүн худалдаалах сүлжээний үйл ажиллагааг таслан зогсоож, хүний наймаачидтай хариуцлага тооцох.

**Тулгуур үйл ажиллагаа 4: Нийтлэг хандлага, институцийн үр нөлөө** - Хамтын ажиллагаагаар дамжуулан урьдчилан сэргийлэх, хамгаалах, яллах ажиллагааг идэвхжүүлэх.

АНУ-ын хувьд эрх зүйн орчиндоо анхаарал хандуулж, асуудлыг цогц байдлаар авч үзэж, мужийн болон холбооны хуулиар зохицуулалт хийж, үйл ажиллагаа тус бүрийг санхүүжүүлдэг бүтцийг манай улс авч хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй. Мөн гэмт хэргийн хохирогчид туслах үндэсний хөтөлбөрөөр дамжуулан тэтгэлэг олгодог ба ХХГХ-ийн хохирогчид болон гэр бүлийн зарим гишүүдэд хэргийн менежмент, лавлагаа, яаралтай тусламжийн (хоол хүнс, хувцас, орон байр гэх мэт) тусламжийг үзүүлдэг. Эдгээр нь орон сууц, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, эмчилгээ, эмнэлгийн бусад үйлчилгээ, хууль эрх зүйн зарим үйлчилгээнд хамрагдах, хүчирхийлэл, мөлжлөгөөс ангид амьдрах боломжийг олгодог<sup>73</sup>.

### 5.2.3. Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх бодлогыг сурталчлах хяналтын баг нь биеэ үнэлэх, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх Засгийн газрын үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй бөгөөд жилд хоёр удаа хуралддаг. Хүн худалдаалахтай тэмцэх бүх үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий нэг ч байгууллага байдаггүй. 2020 оны гуравдугаар сард тус улсын Засгийн газраас бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн эсрэг үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий байгууллагуудын дундын ажлын албыг байгуулсан. Ажлын албыг Гадаад хэргийн дэд сайд удирдах болсон.

<sup>72</sup> Хүн худалдаалахтай тэмцэх АНУ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө <https://www.hsdl.org/?abstract&did=845813>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

<sup>73</sup> <https://www.benefits.gov/benefit/622>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

Бэлгийн мөлжлөгийн асуудлыг биеэ үнэлэгчийн хувийн асуудал гэж авч үздэг байсан боловч 2000, 2002 онуудад бэлгийн мөлжлөгт өртсөн 15 эмэгтэй амиа алдсан учир энэ асуудлыг шийдүүлэхээр жагсаал, цуглаан хийж, улс даяар хөдөлгөөн өрнөснөөр гэмт хэрэгтнүүдээс мөнгө авдаг тогтолцоог илчилсэн. Хуулийг шаардаж, батлуулахад ТББ-ын дуу хоолой хүчтэй байж олон нийтийн анхаарлыг хандуулж эхэлснээр 2004 онд бэлгийн мөлжлөгтэй тэмцэх тусгай хууль батлагдсан. Хууль батлагдах үед хохирогчийг хамгаалах тогтолцоо бий болгох шаардлагатайг харуулсан тул гэмт хэрэгтнийг шийтгэх, хохирогчийг хамгаалах асуудлыг цогцоор тусгасан. 2009 оноос үйл ажиллагаа идэвхжиж хохирогчдод туслалцаа үзүүлэх төвүүд байгуулагдаж эхэлсэн.

Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх хууль (2004), Биеэ үнэлэх, түүнд зуучлах үйлдлийг шийтгэх тухай хууль батлагдан хэрэгжиж байна. Биеэ үнэлэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тухай хуулиар гурван жил тутамд нэг удаа биеэ үнэлэх талаар судалгаа хийхийг Засгийн газарт үүрэг болгосны дагуу судалгаа хийж, үр дүнд суурилсан үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг.

2013 онд ЖГБТЭЯ-ны олон нийтийн хамтын төслөөр Сөүл хотын “Дахин хамтдаа” ТББ-аас “Бэлгийн мөлжлөгийн хохирогчийг таньж тогтоох удирдамж” (GIST- Guidelines for Identification of Sex-Trafficking victim)-ыг боловруулж, Биеэ үнэлэх, түүнд зуучлах үйлдлийг шийтгэх тухай хуулийг хэрхэн хэрэглэж, ял шийтгэл оногдуулах, хохирогчийг хамгаалалтад авах, хохирлыг барагдуулах, туслалцаа үзүүлэх талаар хуулийн зохицуулалт тус бүрийг кейст тулгуурлан, хэрхэн хэрэглэх удирдамжийг боловсруулан улсын хэмжээнд нэгдсэн журмаар хэрэглэж байна.

Солонгос улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг эрт илрүүлж, хамгаалах зорилгоор “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, хамгаалах 27 индекс”-ийг батлуулж<sup>74</sup>, хэрэгжүүлэх сургалтыг холбогдох төрийн байгууллагуудад хийж байна.

Засгийн газар хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэх тусгай шууд утсыг ажиллуулаагүй ч ЖГБТЭЯ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан 13 өөр хэлээр шууд утас ажиллуулж, шаардлагатай хохирогчдод зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг.

Шүүх хуралдааны үеэр гэрчээр оролцож байгаа насанд хүрээгүй хохирогчийг мэдүүлэг өгөхөөсөө өмнө тангараг өргөхөөс чөлөөлөх, хохирогчийг эцэг эх, асран хамгаалагчтай хамт орохыг зөвшөөрөх, видео болон бусад цахим хэлбэрээр гэрчийн мэдүүлэг өгөх, хүүхдэд үзүүлэх хууль зүйн үйлчилгээний төлбөрийг цуцлах зэргээр хамгаалдаг.

<sup>74</sup> Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тодорхойлох, хамгаалах индекс, СХЭҮК, 2016 оны 9-р сар <https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?menuid=002002001&boardtypeid=7003&boardid=7001828>, (сүүлд үзсэн: 2021.09.20).

Гэрчийг хамгаалах хөтөлбөрөөр дамжуулан хууль зүйн зөвлөгөө өгөг, эмнэлгийн тусламж үзүүлэх, эх орондоо ирэхэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах, түр оршин суух байраар хангах зэрэг тусламж үйлчилгээ үзүүлдэг.

БНСУ-ын ХХГХ-тэй гэмт хэрэгтэй тэмцэж буй гол онцлог нь бэлгийн мөлжлөгийн хохирогчийн асуудалд онцгой анхаарал хандуулж, хохирогчдод 36 сар хүртэл цогц туслалцаа, нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлдэг. Цагдаагийн албан хаагчдад бэлгийн мөлжлөгийн хохирогчийг таних, хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулж, хууль сахиулагчид бэлгийн мөлжлөгт өртсөн иргэдийг ЖГБТЭЯ -ны харьяа байгууллагуудад шилжүүлсэн. Тус яам нь гэмт хэргийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг 96 байгууллагын үйл ажиллагааг дэмжиж ажилладаг. Хохирлыг тооцохдоо хуулиар нэг хохирогчид нөхөн сэргээх зардлыг дөрвөөс долоон сая воноор тооцдог (2019 оны байдлаар). ЖГБТЭЯ-ны харьяа “Наранцэцэг” төв нь аюултай үеийн яаралтай тусламж, хүүхдийн тусламж, нэгдсэн тусламж гэсэн гурван төрлийн үйлчилгээг орон даяар 39 салбар төвтэйгээр үзүүлж байна. Эдгээр төвөөр дамжуулж зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мөрдөн байцаалт эрх зүйн тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ, байгаа газарт нь очиж үйлчлэх, нийгмийн үйлчилгээг ойртуулах<sup>75</sup> зэрэг үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлдэг.

#### **5.2.4. Бүгд Найрамдах Хятад Ард Улс**

Нийгмийг аюулаас хамгаалах яам нь хүн худалдаалахтай тэмцэх байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулж, 2013-2020 оны Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллагууд хоорондын үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Засгийн газраас 2016 онд 55 сая юань (7.9 сая ам доллар)-ыг хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд зарцуулахаар төсөвлөж байсан. Биеэ үнэлэлт болон албадан буюу захиалгат гэрлэлтийн дунд хүн худалдаалах хэргийн хохирогчийг таньж тогтоох журмыг тодруулах зорилгоор 2016 оноос улсын хэмжээнд хууль сахиулах

байгууллагуудын албан тушаалтнуудад бичгээр өгсөн зааварчилгааг ашигладаг байна.

БНХАУ биеэ үнэлэх гэмт хэрэгт холбоотой (бэлгийн мөлжлөг орно) байгууллагыг хаацайлдаг, түүнээс ашиг олдог, эрх мэдэл, нөлөөгөө ашиглан авлигын гэмт хэрэгт холбогдсон албан тушаалтнууд болон цагдаагийн албан хаагчдыг мөрдөн шалгах кампанит ажлыг улсын хэмжээнд хэрэгжүүлдэг.

Хууль сахиулах байгууллагууд нь гадаад орнуудын засгийн газартай хамтран өмнөд болон Зүүн өмнөд Азийн орнуудад хүн худалдаалах хэрэгт өртсөн БНХАУ-ын иргэдийн хэргийг мөрдөн шалгадаг. Тус орны засгийн

<sup>75</sup> БНСУ-ын Жендэр, гэр бүл, тэгш эрхийн яамны харьяа “Наранцэцэг төв”-ийн танилцуулга, “2019 оны үйл ажиллагааны тайлан”, 2019 он.



газар нь Монгол Улс болон Доод Меконгийн таван улсын хууль сахиулах байгууллагуудтай хамтран эдгээр орны иргэдийг БНХАУ-д амьдардаг иргэдтэй албадан буюу захиалгат гэрлүүлэх замаар үйлдэгдсэн хүн худалдаалах хэргийг шийдвэрлэхэд анхаарал хандуулдаг. Иргэний хэргийн яам, улсын хэмжээний эмэгтэйчүүдийн байгууллага, ТББ-ууд хохирогчдод хамгаалах байр, эмнэлгийн тусламж, зөвлөгөө өгөх, хууль зүйн туслалцаа үзүүлэх, нийгмийн үйлчилгээ үзүүлэхээс гадна зарим тохиолдолд сэргээх заслын үйлчилгээ үзүүлдэг. Засгийн газраас хүн худалдаалах гэмт хэргийн дотоодын хохирогчдод зориулагдсан дор хаяж 10 хамгаалах байр, түүнчлэн гадаад хохирогчдод зориулсан найман хамгаалах байр, улсын хэмжээнд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг байрлуулах боломжтой 2300 гаруй олон төрлийн зориулалтаар ашиглах хамгаалах байр ажиллуулдаг талаараа мэдээлжээ.

Нийгмийг аюулаас хамгаалах яам нь хүн худалдаалахтай тэмцэх байгууллагууд хоорондын үйл ажиллагааг зохицуулж, хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны нөлөөллийн судалгааг багтаасан 2013-2020 оны БНХАУ-ын хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг<sup>76</sup> хэрэгжүүлдэг.

Нийгмийг аюулаас хамгаалах яам нь олон улсын хамтын ажиллагааны хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх Меконгийн сайд нарын хамтарсан санаачилга (СОММИТ санаачилга)<sup>77</sup>-д нэгдэж хүн худалдаалахын эсрэг уялдаатай, цогц хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулах дээд зохицуулалтын байгууллага юм. СОММИТ санаачилга нь хүн худалдаалахтай тэмцэх ажилд хамааралтай яамдын төрийн албан хаагчдаас бүрдсэн зургаан улсын ажлын алба удирддаг бөгөөд хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, нутаг буцаах, нийгэмшүүлэх, холбогдох гэмт хэрэгтэнд ял шийтгэл оногдуулах талаар хамтран ажилладаг. СОММИТ ажлын алба нь улс орондоо хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөр, бодлогын талаарх бүхий л том шийдвэрийг гаргадаг бөгөөд тус санаачилгын хөтөлбөрийг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусгаж өгдөг онцлогтой.

---

<sup>76</sup> Хүн худалдаалах гэмт хэргийг таслан зогсоох Төрийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, БНХАУ-ын хуулийн орчуулга, <https://www.chinalawtranslate.com/en/state-council-action-plan-for-stopping-human-trafficking/>. (сүүлд үзсэн: 2021.09.20).

<sup>77</sup> Хүн худалдаалахтай тэмцэх Меконгийн сайд нарын хамтарсан санаачилга (СОММИТ санаачилга), ОУШХБ <https://www.iom.int/coordinated-mekong-ministerial-initiative-against-trafficking-commit-process>. (сүүлд үзсэн: 2021.09.20).

## ДУГНЭЛТ

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

### 1. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин, бодлогын хэрэгжилтийн чиглэлээр:

- **Эрх зүйн орчин боловсронгуй болсоор байна.** Монгол Улс 2002 оноос эхлэн эрх зүйн орчноо боловсронгуй болгох чиглэлээр тасралтгүй ажилласаар иржээ. НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орж, соёрхон баталснаар өөрийн орны хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэн, Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг батлан гаргаж, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийг байгуулан үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.
- **Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бий болсон байна.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчдод үзүүлэх таван төрлийн үйлчилгээг хуульчилж, төрөөс бүрэн санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд үйлчилгээ үзүүлэх долоон журмаас тавыг нь батлагдсан байна. ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээ үзүүлэх стандартыг баталж, ТББ-ууд мөрдөж ажиллахаар зохицуулсан нь хүний эрх, хохирогч төвтэй хандлагыг бүх түвшинд төлөвшүүлж ажиллахад дөхөм болсон байна.
- **Эрх зүйн орчин тодорхой болсон ч нэгдсэн аргачлал, удирдамжгүй байна.** Төрийн болон ТББ-ын аль алинд нь хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамж байхгүй, байгууллага тус бүр өөр өөр бичиг баримтын хүрээнд хохирогчоо тогтоож байна. Иймд үндэсний хэмжээнд ХХГХ-ийн хохирогчийг таньж мэдэх, илрүүлэх, тогтоох нэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжийг боловсруулах, батлуулах хэрэгцээ бий болжээ.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн туслалцаа, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа байхгүй байна.** Өнөөг хүртэл төрийн болон ТББ-ын зүгээс хохирогчдод үзүүлсэн туслалцааны талаарх тоо мэдээ зөрүүтэй байгаа бөгөөд ТББ-ууд илүү олон үйлчлүүлэгчдэд үйлчилгээ, туслалцаа үзүүлсэн байна.
- **Хохирол нөхөн төлүүлэх, нөхөн олговор олгох тогтолцоо үгүйлэгдэж байна.** Хохирогчид хуулийн байгууллагад хандсан ч хохирлоо барагдуулж чадаагүйдээ гомдолтой байна. Хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх тал дээр бодитой үр дүн, шийдлийг хүлээж хуулийн байгууллагад ханддаг ч санаснаар шийдвэрлэгддэггүйд сэтгэл хангалуун бус хоцорч байна.

## 2. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний талаар:

- **Хохирогч хуулийн байгууллагад өөрөө шууд хандах талаар нөлөөллийн ажил хэрэгтэй байна.** Хохирогчийг олон арга замаар илрүүлж, туслалцаа үзүүлж байгаа ч хохирогч өөрөө цагдаа, хуулийн байгууллагад хандаж туслалцаа авахдаа асуудалд болгоомжтой хандаж байна. Гэмт хэрэгтнүүд “цагдаа найзтай, танилтай, эсвэл цагдаад хэлж баривчлуулна, хориулна, торгуулна” гэх мэт сэтгэл зүйн дайралт, заналхийллийн арга хэрэглэдгээс цагдаагаас айх, болгоомжлох явдал байсаар байна.
- **Эрсдэлд өртсөн хохирогчид шуурхай тусламж, үйлчилгээ авах боломж бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.** ХХГХ-т өртөх эрсдэлтэй тулгарсан хохирогч хаана, хэнд хандаж үйлчилгээ авах талаарх мэдээлэл дутмаг. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, сурталчилгааг мэдээллийн хэрэгслээр дамжуулан (цахим болон нийгмийн сүлжээ, зөвлөгөө өгөх утас, телевиз, радио, тараах материал гэх мэт) түгээж байгаа ч тогтмол биш байгаа нь хангалттай үр дүн үзүүлэхгүй байна.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний тогтолцоо бүрдээгүй байна.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарах ёстой хохирогчдод үзүүлэх үйлчилгээний журмууд бүрэн гараагүй байхын зэрэгцээ батлагдсан журмууд нь салангид, хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгжилт туйлын сул байна. Хохирогчид төрөөс хуульд тусгагдсан үйлчилгээг өнөөг хүртэл бүрэн авч чадахгүй зөвхөн ТББ-аас үзүүлж буй үйлчилгээнд хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагуудад хохирогчид руу чиглэсэн нийгмийн ажил үйлчилгээ болон нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх цогц үйлчилгээ байхгүй байна.
- **Хохирогч төрөөс хуульчлагдсан үйлчилгээг үнэ төлбөргүй авч чадахгүй байна.** Хохирогчдод зориулсан үйлчилгээ нэгэн цогц болж чадаагүйгээс хариуцах эзэнгүй болж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаар мэдээлэл дутмаг, хэрэгжүүлэх боловсон хүчин бэлтгэгдээгүй, тусгайлсан төсөв байхгүй зэргээс шалтгаалан хохирогч өөрт нь зориулсан үйлчилгээг хаанаас, хэрхэн авах талаар мэдээлэлгүй, туслалцааг шууд авах боломж хязгаарлагдмал хэвээр байна.
- **Хохирогчийн хүссэн үйлчилгээг үзүүлэх боломж хязгаарлагдмал байна.** Хохирогчид төрийн болон ТББ-ын туслалцаанд хамрагдаж эхэлсэн цагаасаа эхлэн анхан шатны хэрэгцээгээ хангах бэлэн мөнгөний дэмжлэг, туслалцаа хүсдэг боловч энэ нь бүрэн хангагдах боломжгүй байна. ТББ-ууд хүний анхан шатны хэрэгцээг хангахад тусалдаг ч тогтмол, удаан хугацаанд үзүүлэх боломжгүй байдаг.

### 3. Хохирогч хамгаалал, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар:

- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ хэрэгцээтэй байна.** Хохирогчдод үзүүлж байгаа үйлчилгээ нь дийлэнх тохиолдолд анхан шатны хэрэгцээнд суурилсан үйлчилгээгээр хязгаарлагдаж буй бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг эргэн хэвийн амьдралд нь ороход удаан хугацааны, тогтвортой үйлчилгээ хэрэгтэй юм. Нөгөө талаас нэг үйлчлүүлэгчдэд ногдох үйлчилгээний зардал өндөр учир нэг хүнийг удаан хугацаанд үйлчилгээнд хамруулахад ТББ-уудад хүндрэлтэй байдаг.
- **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байна.** Хохирогч амьдарч буй орон нутагтаа шууд туслалцаа, урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах нөхцөл, боломж хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл орон нутагт энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн байгууллага одоогоор байхгүй.
- **Эрсдэл өндөртэй гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан байр байхгүй.** Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Аюулгүй байдлыг хангах журмаар эрсдэлийн гурван түвшинг тогтоож, эрсдэлийн түвшин өндөр гэрч, хохирогчийг төрөөс тусгай хамгаалах байраар хангах үүрэг хүлээсэн боловч хэрэгжээгүй. Эрсдэлийн өндөр түвшинд байгаа гэрч, хохирогчийг байрлуулах тусгай хамгаалах байр байхгүй учир эрсдэлийн түвшингээр үнэлж, хамгаалан байрлуулах боломжгүй ТББ-ын хамгаалах байруудад байрлуулж байгаа нь хохирогчдод болон тухайн байгууллагад учрах эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой тул яаралтай анхаарал хандуулах шаардлага бий болжээ.
- **Хохирогчийн хувийн мэдээллийн нууцлалыг ханган ажиллахад анхаарах шаардлагатай байна.** Үйлчилгээ үзүүлэх явцдаа төрийн болон ТББ-ууд хувь хүний нууцыг хамгаалж, хохирогч, түүний гэр бүлийг дахин эрсдэлд өртөхгүй байх баталгааг хангах шаардлагатай байна. Төрийн болон ТББ-ууд холбон зуучлах, бусад үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийн хувийн нууцыг хадгалж хамгаалах талаар гэрээ байгуулах зэрэг ажил хангалттай түвшинд хийгдэхгүй байна.
- **Насанд хүрээгүй хохирогчдод онцгойлон анхаарал хандуулан, дагнсан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна.** Хохирогч хүүхэд нь насанд хүрсэн хохирогчтой харьцуулахад бие махбод, сэтгэлзүйн хувьд бүрэн хөгжөөгүй, шийдвэр гаргах чадваргүй, насанд хүрэгчдээс хараат зэргээс шалтгаалан түүнд үзүүлэх үйлчилгээ нь ялгаатай гэдгийн хүлээн зөвшөөрч ажиллах, тусгайлан үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна. Хохирогч эргэн хэвийн амьдралдаа ортол нэгээс гурван жилийн хугацаа шаардлагатай ба ар гэрийн

нөхцөл байдлаас шалтгаалан хэвийн амьдралдаа орох хугацаа харилцан адилгүй. Олонх хохирогч бүх шатны шүүхээр хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл гэмт хэрэгтнүүдтэй огт харьцахгүй байх боломжтой тусгай байранд байрлуулж, нууцлалыг хангаж өгөхийг хүсдэг ч хэрэгжих боломжгүй байна.

#### **4. Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн талаар:**

- **Үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийг тогтвортойгоор сургах, чадавхжуулах хэрэгцээтэй байна.** Үйлчилгээ үзүүлж буй төрийн болон ТББ-ын мэргэжилтнүүдийг хохирогч төвтэй хандлага, аргачлалд тогтмол сургах, мэргэшүүлэх ажлыг хамтран тогтвортойгоор хэрэгжүүлэх чухал. Мэдээллийн хүртээмж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэж буй байдлаасаа шалтгаалан үйлчилгээ үзүүлэгчид харилцан адилгүй түвшинд ажиллаж байна. Төрийн болон ТББ-д мэргэшсэн ажилтнуудыг тогтвортойгоор ажиллуулах бодлогын шийдэл үгүйлэгдэж байна.

#### **5. Хохирогч хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн талаар:**

- **Төрөөс хохирогчийн үйлчилгээнд зориулсан олгох тогтмол төсөв, санхүүжилт хангалтгүй байна.** Сүүлийн гурван жилд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлөөс хохирогчид шууд туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд тодорхой санхүүжилтийг хуваарилж буй боловч бизнесийн байгууллагуудын нэгэн адил шалгуураар тендерээр авах болдог нь ТББ-д хүндрэлтэй байна. Хохирогчдод үзүүлж буй үйлчилгээ нь өнөөг хүртэл олон улсын санхүүжүүлэгч байгууллагын тусламж, дэмжлэгээр хэрэгжиж байна.
- **Төрөөс тендерийн хуулийн дагуу авч буй санхүүжилтэд зайлшгүй байх ёстой зардлууд тусгагдаж чадахгүй байна.** Хохирогчид туслалцаа үзүүлэх ажлын гол бүрэлдэхүүн хэсэг болох үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын цалин, байрны түрээс, байгууллагын урсгал зардал зэрэгт мөнгө хуваарилдаггүй нь ТББ-ууд үйлчилгээний чиглэлээр ажиллах идэвх сонирхлыг бууруулж байна. Цаашид төрөөс хохирогч хамгаалал, ялангуяа үйлчилгээнд батлагдсан журам, стандартын хэрэгжилтийг бодитоор хангах тусгайлсан төсөв хуваарилах, батлуулах хэрэгцээ бий болсон байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

Үүнд:

### **1. Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд:**

- Төр болон ТББ-ууд хамтран хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамж боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;
- ХХГХ-ийн хохирогчид үзүүлсэн туслалцаа, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээллийн сан үүсгэх;
- Хохирол нөхөн төлүүлэх, нөхөн олговор олгох тогтолцоо бүрдүүлэх;
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг дагаж гарах журмуудыг засан сайжруулах, яаралтай батлах, хэрэгжилтийг хангах.

### **2. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний хүрээнд:**

- Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгож, үйлчилгээг үнэ төлбөргүй болгох;
- Үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй төрийн болон ТББ-ын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрх зүйч, хуульчдыг тогтвортойгоор сургах, чадавхжуулах, туршлага солилцох замаар хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх.

### **3. Хохирогч хамгаалал, үйлчилгээний чанар, хүртээмжийн хүрээнд:**

- Төрөөс ТББ-д олгох ХХГХ-ийн хохирогчдод урт хугацааны үйлчилгээ үзүүлэх хангалттай санхүүжилтийг тусгах, хуваарилах;
- Эрсдэл өндөртэй орон нутагт хохирогчдод үйлчилгээ үзүүлэх ТББ-уудыг бий болгож, хүний нөөцийг чадавхжуулах, орон нутгаас санхүүжилт авах боломжийг бүрдүүлэх;
- Эрсдэл өндөртэй, гэрч, хохирогчийг хамгаалах байрыг ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах газрын дэргэд байгуулах;
- Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, ялангуяа насанд хүрээгүй хохирогчдод үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг бусад орны туршлага дээр тулгуурлан боловсруулж, турших, хэрэгжүүлэх.

### **4. Хохирогч хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн хүрээнд:**

- Төрийн байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн үйлчилгээнд зориулсан тогтмол төсөв, санхүүжилт хуваарилах.

## **АШИГЛАСАН МАТЕРИАЛ**

### **Олон улсын гэрээ**

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц ба түүний нэмэлт (2000)

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (2000)

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол (2000)

### **Хууль тогтоомж**

Эрүүгийн хууль (2015)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)

Улсын дээд шүүхийн тогтоол (2008)

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай (2013)

Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)

Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6040:2009 Монгол Улсын стандарт)

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, MNS 6418:2013, Монгол Улсын стандарт

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6040:2019 Монгол Улсын стандарт)

### **Гарын авлага, судалгааны тайлан**

Хила Шамир, “Хүн худалдаалах хэргийн хөдөлмөрийн парадигм”, Калифорнийн их сургууль, Лос Анжелес, Хуулийн тойм

Доктор Мария Йованович, “Хүн худалдаалахтай тэмцэх хууль эрх зүйн дэглэм ба Европын Зөвлөл ба АСЕАН-ны харьцуулалт: Бодит байдал, хүрээ, хамтын ажиллагааны боломжууд”

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тодорхойлох, хамгаалах индекс, СХЭҮК

БНСУ-ын Жендэр, гэр бүл, тэгш эрхийн яамны харьяа Наранцэцэг төвийн танилцуулга, 2019 оны үйл ажиллагааны тайлан

НҮБ-ын Хүний эрхийн Дээд комиссарын Хүний эрх болон хүн худалдаалах хэргийн талаар баримтлах зарчим, удирдамж

Г.Ганбаясгах, Э.Хишигбаяр. (2020). Биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөгийн талаарх олон нийтийн үзэл хандлага, тулгамдаж буй асуудал илтгэл. Улаанбаатар хот



ЖҮХ. (2019). МУ-ын Жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ:2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж тайлан, Улаанбаатар хот  
Л.Галбаатар. (2019). Гэрч, хохирогчийн хамгаалалт бодлогын судалгааны тайлан. Улаанбаатар хот

Хүн худалдаалахтай тэмцэх Дэд зөвлөл. (2020). Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт. Улаанбаатар хот

### **Вебсайт**

<https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>  
[https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg\\_no=XVIII-12-a&chapter=18&clang=\\_en](https://treaties.un.org/pages/ViewDetails.aspx?src=TREATY&mtdsg_no=XVIII-12-a&chapter=18&clang=_en)  
<https://www.uclalawreview.org/pdf/60-1-2.pdf>  
<http://www.mnb.mn/i/134112>  
<https://www.state.gov/wp-content/uploads/2020/06/2020-TIP-Report-Complete-062420-FINAL.pdf>  
<https://estandard.gov.mn/standard/v/3667>  
<https://www.legalinfo.mn>  
<https://www.legalinfo.mn/law/details/9287?lawid=9287>  
<https://rm.coe.int/coe-asean-study-thb/16808c1b91>  
<https://www.justice.gov/opa/pr/justice-department-awards-nearly-101-million-combat-human-trafficking>  
<https://immsolutionsllc.com/immigration/visas-victims-crimes-abuse/t-visa>  
<https://www.iom.int/coordinated-mekong-ministerial-initiative-against-trafficking-commit-process>  
<http://kidnap.bz.cn/html/aboutEnglish/>  
<https://www.state.gov/the-presidents-interagency-task-force/>  
[https://www.justice.gov/humantrafficking/whole-government-approach#:~:text=U.S.%20Department%20of%20Homeland%20Security&text=U.S.%20Immigration%20and%20Customs%20Enforcement%20\(ICE\)%2C%20the%20largest%20investigative,human%20smuggling%20and%20human%20trafficking.](https://www.justice.gov/humantrafficking/whole-government-approach#:~:text=U.S.%20Department%20of%20Homeland%20Security&text=U.S.%20Immigration%20and%20Customs%20Enforcement%20(ICE)%2C%20the%20largest%20investigative,human%20smuggling%20and%20human%20trafficking.)  
<https://www.hsdl.org/?abstract&did=845813>  
<https://www.benefits.gov/benefit/622>  
<https://www.humanrights.go.kr/site/program/board/basicboard/view?menuid=002002001&boardtypeid=7003&boardid=7001828>  
<https://www.chinalawtranslate.com/en/state-council-action-plan-for-stopping-human-trafficking/>  
<https://www.iom.int/coordinated-mekong-ministerial-initiative-against-trafficking-commit-process>  
<https://www.tender.gov.mn/mn/invitation/detail/1618540128859>



“Мөнхийн Үсэг” ХХК-д хэвлэв.  
Утас: 319658, 70140459  
Вэб хаяг: [www.munkhiin-useg.mn](http://www.munkhiin-useg.mn)